



ХӨВСГӨЛ АЙМАГ
ЦАГААН-ҮҮР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 02

Булган

Сумын Засаг даргын үйл
ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд
үнэлэлт дүгнэлт өгөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “д” заалт, 36 дугаар зүйлийн 36.1.2 заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1 заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит XI хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын “ Хариуцлага, хамтын ажиллагаа, найрсаг Цагаан-Үүр ” 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг 77.9 хувийн биелэлттэй гэж дүгнэсүгэй.

2. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлттэй холбоотой Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөөс гарсан саналыг үйл ажиллагаандаа тусгаж, цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийг гүйцэтгэлийн үр дүнд тулгуурлан бодит тоо, судалгаанд үндэслэн биелэлтийг тооцож ажиллахыг сумын Засаг дарга Д.Далай/-д даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд даалгасугай .

ДАРГА



Н.МЯГМАРСҮРЭН



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-ҮҮР СУМ

**СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
“НАЙРСАГ ЦАГААН-ҮҮР” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

2019 ОН

БУЛГАН

**СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
НАЙРСАГ ЦАГААН-ҮҮР ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО**

2019. 12.16

Булган

№	Чиглэл	бодлогын зорилт	Арга хэмжээн тоо	100	70	40	0	ҮБ	Хэрэгжилтийн хувь
А. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
1	Эрүүл мэнд спорт	5	20	7	12	1			79%
2	Боловсрол, соёл	5	28	8	12	8			70%
3	Хүүхэд гэр бүл	1	4	1	2	1			70%
4	Хөдөлмөр эрхлэлт	1	4	3	1				92.5%
5	Нийгмийн халамж	2	10	9	1				97%
81.7%									
Б. ЭДИЙН ЗАСАГ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
6	Санхүү, эдийн засаг	1	8	6	2				92.5%
7	Хөдөө аж ахуй	2	11	2	5	4			64.5%
8	Байгаль орчин	3	8	1	6	1			70%
9	Аялал жуулчлал	1	7	1	3	3			61.4%
10	Сумын төв, суурин газар	1	6	1	2	3			60%
11	Дэд бүтэц	1	10	2		7	1		53%
66.9%									
В. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО									
12	Төрийн алба	1	6	2	4				80%
13	Хууль зүй	1	7	4	2	1			82.8%
14	Худалдан авах ажиллагаа	1	4	3	1				92.5%
85.1%									
	Нийт дүн	26	132	52	52	27			77.9%

ТАНИЛЦСАН: ЗАСАГ ДАРГА

Д. ДАЛАЙ

ХЯНАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА

Д. ЦОГТ-ЭРДЭНЭ

НЭГТГЭСЭН: ДАЭЗССХМЭРГЭЖИЛТЭН

Д. БОЛОР-ЭРДЭНЭ

**СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
НАЙРСАГ ЦАГААН-ҮҮР ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

2019.12.16

Булган

Аймгийн Засаг Даргын Хөтөлбөрт туслагдсан байдал	Арга хэмжээний дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ,	Зорилтот түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
Үндэснийхээ үнэт зүйлийг өвлөн иргэн бүр эрүүл, боловсролтой, бүтээлч, ажил орлоготой, хүмүүнлэг, өв тэгш гэр бүлийг дэмжин тэтгэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.							
Нэг. Эрүүл мэнд-спорт							
1. Хүн амын эрүүл мэндийг хувь хүн, гэр бүл, ААН-ийн оролцоотойгоор хамгаалж дэмжинэ							
	1	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжихэд улсын үндэсний төвүүд, нэгдсэн эмнэлэгүүдийн дэмжлэг авч, хамтын ажиллагаа түншлэлийн бодлогыг сумандаа хэрэгжүүлнэ.				1. Аймгийн “Нэгд”, “Мөнх тулгуур” эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар суманд 2-3 өдөр ажиллаж эхөд 258 хүн, зүрх судасны нарийн мэргэжлийн эмчид 154, нүдний эмчийн үзлэгт 53, зүрхний бичлэг 152 хүн, хеликобактер, хавдар, цусны дэлгэрэнгүй шинжилгээнд 96 хүн тус тус хамрагдаж зөвлөгөө авсан. 2. 6-с дээш насны хүн амд асуумжит үзлэгийг зохион байгуулж нийт 261 /11%/ хүнээс авч, 20 хүний сүрьеэгийн сорьц цэрний шинжилгээ тээвэрлэн хүргэж өгсөн. /Сүрьеэтэй 1 хүн эмчийн хяналтанд эмийн эмчилгээний тасралтгүй эмчилж байна./ 3. Улаанбаатар хотын хавдар судлалын үндэсний төвийн эмэгтэйчүүдийн хавдрын тасгийн эрхлэгч болон эмч нарын баг суманд ажиллаж эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэг,хэт авиан оношилгоонд 125 хүнийг хамруулж 35 хүнээс хавдрын эсийн шинжилгээ авч хариуг илгээж өвчлөлтэй илэрсэн 85 хүнд эмчилгээ зөвлөгөө өгсөн. Нарийн мэргэжлийн эмч нар тусламж үзүүлснээр иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чирэгдэл буурч иргэдийн сэтгэл ханамж дээшилсэн байна.	Б-100
	2	Эх, хүүхдэд ээлтэй байгууллага,баг, сум болох нөхцлийг бүрдүүлж хангана.				Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулах Аймгийн ЗД-ын А/79, А/02 тушаалын дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан улирал бүр тайлан мэдээг явуулдаг бөгөөд	ХШ-70

	3	Хүн амыг аюулгүй ус, хүнсээр хангах, орчны ариун цэврийн байдлыг сайжруулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах арга хэмжээг зохион байгуулна.		
	4	Иргэдийн архи, тамхины хэрэглээг багасгах талаар шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэн сахилга хариуцлага урамшууллын хөшүүргийг оновчтой ашиглан идэвхтэй үйл ажиллагаа явуулна		

жирэмсний эхний 3 сартай хяналт 90,5%-тай байна. Жирэмсэн эхчүүдийг сар бүр нэр, багаар нь ЭМТ-н дарга, баг хороо хариуцсан сувилагч мэргэжилтэнүүд болон сумын засаг даргын өрөөнд байрлуулж давхар хяналтыг сайжруулан ажиллаж байна. Энэ онд өрх толгойлсон эрсдэлтэй бүлгийн 2 эхэд хилийн застав, нийгмийн халамж болон эрүүл мэндийн төв хамтран 850 мянган төгрөгний буцалтгүй тусламж Эрүүл мэндийг дэмжих байгууллага аймгийн эрүүл мэндийг дэмжигч байгууллагаар сургуулийн өмнөх боловсролын "Цоморлог" цэцэрлэг эрүүл мэндийн дэмжигч байгууллага болж дараагийн шатлал улсын эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна. 2019 онд төрсөн амжиргааны түвшин доогуур 5 ээжид төрөх болон төрсний дараа хэрэглэдэг зайлшгүй шаардлагатай зүйлүүдийг бэлдэж өгсөн.

Эрүүл ахуйн 3-н дадал аяны хүрээнд ариун цэврийн байгууламжийг сайжруулах, стандарт шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болох сурталчилгааг зохион байгуулж гарын авлага 97 иргэнд өгсөн. Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрх 5 өрх байна. Сумын хэмжээнд сургууль, цэцэрлэг, Засаг даргын тамгын газар эрүүл мэндийн төв сайжруулсан ариун цэврийн байгууламжтай. Сумын 4 гүний худгийн усны дээжийг шинжилгээнд хамруулахад бактер нян илэрсэн. Сургууль усны шинжилгээг дахин өгч шинжилгээний хариу хэвийн гэж ирсэн. Иргэдэд хог ангилан ялгах талаар "Эрүүл ахуйн 3-н дадал эрүүл үндэс" сэдэвт сургалтыг 4 удаа 86 хүнд зохион байгуулж 205 хүнд сурталчилгааны материал тарааж заавар зөвөлгөө өгсөн. Эрүүл мэндийн төв нь хог хаягдлыг хадгалах түр байрыг шинээр барьж ашиглалтанд оруулсан.

Тамхи татахгүй өдрөөр байгууллага бүрийн гаднах тамхины ишийг албан байгууллагын албан хаагч нараар өөрсдөөр нь түүлгэн "Та тамхийг биш Тамхи таныг татаж байна" гарын авлага наасан гялгар уутанд тамхины ишийг түүлгэн хогийн саванд хийлгэсэн. Иргэд 47 болон өсвөр үеийн 53 сурагчдад "Архи тамхи шинэ үеийн сонголт биш", "Тамхитай холбоотой эмгэгүүд" сэдвээр сургалтыг хийсэн. 2 хүнийг тамхинаас гаргаж эрүүлжүүлж ар гэрийг дам тамхидалтаас сэргийсэн. Архинаас гаргах эмчилгээнд 5 хүн хамруулж 1 иргэн архинаас гарсан.

Б-10

ХШ-70

5	Эрүүл гэр бүл, байгууллага болох хөдөлгөөн өрнүүлж “Би эрүүл бол, та эрүүл” хөтөлбөр аяныг эхлүүлж иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлнэ.			Эрүүл ахуйн 3-н дадал аяны хүрээнд ариун цэврийн байгууламжийг сайжруулах, стандарт шаардлага хангасан сурталчилгааг зохион байгуулж гарын авлага 97 иргэнд өгсөн. Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрх 5, стандарт хангасан ариун цэврийн байгууламжтай өрх байхгүй ариун цэврийн байгууламжаа тусдаа биш муу усны нүхээ цуг барьж байгаа нь санхүү хүрэлцэхгүй байна гэсэн хариултыг өгч байна. Сумын хэмжээнд сургууль, цэцэрлэг, Засаг даргын тамгын газар эрүүл мэндийн төв сайжруулсан ариун цэврийн байгууламжтай.	ХШ-70
2. Хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлж, эрт илрүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.					
6	-Анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх орчин нөхцлийг бүрдүүлж хүний нөөц, тоног төхөөрөмж, эм хангамжийг шаардлагын дагуу шийдвэрлэж нийгмийн баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.			Эрүүл мэндийн төв нь эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хөтөлбөр хэрэгждэг хөтөлбөрийн хэрэгжилт 84 хувьтай байна. Турк улсын ТИКА-гийн олон улсын байгууллагаас төсөл авч эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, оношилгоо, эмчилгээг сайжруулах үүднээс 10 нэр төрлийн сүүлийн үеийн оношилгоо шинжилгээний аппаратыг шийдвэрлүүлэхээр болсон байна.	Б-100
7	Сумын иргэдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт жил бүр хамруулж, халдварт болон ХБӨ-ийг эрт илрүүлэх, тандалт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.			2018 онд элэг бүтэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан “Эрүүл цус –ээрэг хандлага” аяны хүрээнд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 3958500 төгрөгийн оношлуурын зардлыг шийдүүлж, зорилтот насны иргэдийн оношилгоо шинжилгээний хамрагдалт 80.5% байсан. Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хэрэгжилт 2017-2019 оны хугацаанд нийт 15-65 насны 1740 хүнийг хамруулах зорилготой ба үүний 1188 хүнийг үзлэг шинжилгээнд өнөөдрийн байдлаар хамруулсан байгаа нь 64,2%-тай байна. Хөтөлбөрийн хугацаанд хүн амаа 100% хамруулах зорилго тавьж ажиллаж байгаа ба иргэдийн зүгээс эрүүл мэндийн даатгалын хамрагдалт хангалтгүй байгаа учир хувь төдийлөн өсөхгүй байна. Шинжилгээнд хамрагдсан иргэдээс өвчлөл илэрсэн 128 тохиолдол бүртгэгдэж нийт 108 иргэн тоолох шинжилгээнд хамрагдаж эм уух шаардлагатай 61 иргэн эмээ ууж, дахин ачаалал тоолох шинжилгээнд 49 иргэн хамрагдсан байна. Энэ хөтөлбөрийн үр дүнд хорт хавдраас урьдчилан сэргийлж иргэд өвчлөл илэрсэн тохиолдолд ачаалал тоолуулан эмээ тасралтгүй ууснаар вирусийн идэвхжил буурч хавдраас сэргийлэх арга хэмжээ болж байгаа нь үр дүнгээ өгч байна. Мөн вакцинжуулалтанд 74 хамрагдсанаар	ХШ-70

					вирусийн халдвараас сэргийлж байна. Глобал сангаас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийг нийт 1118 хүнд хийж сэжигтэй илэрсэн 38 хүний цэрний шинжилгээг АНЭ-ийн сүрьеэгийн лабораторт хүргэж хариуг хүлээн авсан. Сорьц тээвэрлэлтээр 1 сүрьеэтэй хүн илэрсэн. 2019 онд нийт сүрьеэтэй 3 том хүн эмчлэгдэж 3 хүүхэд урьдчилан сэргийлэх тунгаар эм ууж уусан. Одоогоор 1 хүн үргэлжлэх шатны эмээ ууж байна. 2 том хүн ,3 хүүхэд бүрэн эмчлэгдсэн. Сүрьеэтэй илэрсэн хүний хавьтал болох 24 хүнийг үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан.	
	8	-Иргэдийн сэтгэл ханамжид дүгнэлт хийж анхан шатны тусламж үйлчилгээнд "тэгш бус байдлыг" арилган эрсдэлийг бууруулах хамгаалалтын арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлнэ.			Иргэдээс амбулаториор 184, хэвтэн эмчлүүлэгч 114, нийт 298 хүнээс сэтгэл ханамжийн судалгаа авахад 81.7% эерэг үнэлгээтэй.Иргэдээс санал хүсэлтийг бичгээр, хайрцгаар, байнгын нээлттэй утас ажиллуулж авч байна. Санал асуулгыг нэгтгэн үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.	ХШ-70
	9	Уламжлалт анагаах ухаан, эмийн бус эмчилгээг дэмжиж, орчин үеийн чиг хандлагын дагуу хэрэгжүүлнэ. Энэ зорилгоор ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн экспедицийг урилгаар ажиллуулж сумын нутагт ургадаг эмийн ургамлын нарийвчилсан судалгаа хийлгэж, товхимол бэлтгэж гаргана.			2014 оноос бие бялдар чийрэгжилтийн арга зүйч орон тоогоор ажиллаж эхэлснээс хойш Аймгийн ЗД-ын нөөцөөс 1.0 сая төгрөг, бусад хандив тусламжаар 2.100.0, нийтдээ 3.100.0 төгрөгний дасгалын тоног төхөөрөмж, бумба, утлага, шарлагын аппаратуудаар хангасан. Эмийн бус эмчилгээг нэвтрүүлэх зорилгоор өөрийн орон нутагт ургадаг эмийн ургамалын судалгааг гаргаж үе шаттай арга хэмжээ авч ажиллаж байна. Сумын төвд эмийн бус эмчилгээг түгээн дэлгэрүүлэх үүднээс 1 иргэн 6.0 сая төгрөгний ургамлын хандаар усан ванн эмчилгээг хийх төсөл , мөн ерөнхий боловсролын сургуулийн эмч 5.0 сая төгрөгний 6-8 нэр төрлийн нөхөн сэргээх физик эмчилгээний тоног төхөөрөмж авч албан байгууллага ,аж ахуй нэгж, иргэдэд эрүүл мэндийн тусламж үзүүлж байна. 2019 онд нарийн мэргэжилийн уламжлалтын эмчтэй болсонтой холбоотой сумандаа ургадаг эмийн ургамалаар бичиж хэвлүүлсэн номыг судлах ажлыг зохион байгуулж байна.2020 оноос эмчилгээнд хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.	ХШ-70
3.Нийтийн биеийн тамирыг өргөжүүлж эрүүл,чийрэг иргэдтэй сум болно.						
	10	-Сургууль, цэцэрлэгээр дамжуулан хүүхдийг бага наснаас нь эхлэн боловсролын хандлагад зөв боловсон зан үйлийг төлөвшүүлж, эрүүл чийрэг бие бялдартай иргэн болох угтвар нөхцлийг бүрдүүлнэ.			Хүүхдийн цэцэрлэгийн хүүхдүүдийн Бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшинг тогтооход 3-5 насны нийт 99 хүүхэд хамрагдахаас 74 хүүхэд хамрагдаж 74,7% тай хэрэгжиж байна. Үүнээс 2018 оны 4 сарын байдлаар дэмжлэг хэрэгтэй хүүхдийн тоо- 55 байснаас, 2019 оны 10 сарын байдлаар	ХШ-70

					дэмжлэг хэрэгтэй хүүхдийн тоо -43 хүүхэд болж 12 хүүхдээр буурсан үзүүлэлтэй. Амны хөндийн эрүүл ахуй, гар угаалт, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг өдөр бүр хөгжүүлэх үйл ажиллагаагаар зохион байгуулсанаар Зөв бие засах чадвар эзэмшсэн хүүхэд-98 Гараа угааж хэвшсэн хүүхэд -120 Шүд угаах чадвар эзэмшсэн хүүхэд -110	
	11	-Бие, бялдын чийрэгжилтийн сорил судалгааг тогтмолжуулж, иргэдийн 70-аас доошгүй хувийг хамруулан түүнд суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.			Хүн амын бие бялдын сорилыг хүн амын 50%-иас авч түвшинг тогтоосон. Уламжлалтын эмчтэй болсонтой холбоотой бие, бялдар чийрэгжилтийн сорилоор С, D үнэлгээ авсан иргэдэд дасгал хөдөлгөөн зааж, тогтмол хичээллэх, жин өндрөө тогтмол хянуулж байх, гарын авлага тарааж, зөвлөгөө, зөвлөмж өгч сурталчилгаа хийж байна. /305 хүнд зөвлөгөө мэдээлэл өгч 45 хүнд дасгал хөдөлгөөн зааж өгсөн байна./	ХШ-70
	12	-Сумын онцлогт тохируулан сонгож хөгжүүлэх спортын төрөл болон нийтийг хамарсан арга хэмжээг өргөжүүлнэ			Өвлийн спорт цана, тэшүүр, үндэсний бөхийн төрлийг хөгжүүлэх зорилгоор жил бүр тэмцээнүүдийг зохион байгуулж иргэд, аж ахуй нэгж албан, байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид амжилттай оролцож байна. "Эрүүл ахуйн "3-н дадал аян"-ыг 6-н сарын хугацаатай сумын айл өрх, албан байгууллагуудын дунд зарлаж 1 албан байгууллага 2 өрхийг шалгаруулсан. "Алтан намар", "Хоолны үзэсгэлэн", ахмадуудын дунд буухиа тэмцээн, дуун цэнгүүн зэрэг үйл ажиллагаануудыг холбогдох төлөвлөгөөний дагуу тогтмол зохион байгуулж хэвшүүлсэн. "Осол гэмтлээс сэргийлэх" 1 сарын аяныг зохион байгуулж аж ахуй нэгж албан байгууллага, ард иргэдийн дунд гар бөмбөгийн тэмцээн уралдааныг зохион байгуулж 208 хүнд осол гэмтлээс сэргийлэх мэдээллийг хүргэсэн байна.	ХШ-100
4.Сумын ЭМТ-ийн үйлчилгээнд иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, ил тод, хариуцлагатай, үр дүнтэй "Үйлчлүүлэгч төв"-тэй тусламж үйлчилгээний тогтолцоог бий болгоно.						
	13	Иргэн- эрүүл мэнд" явуулын нүүдлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохион байгуулна.			Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор сумын ЭМТ-өөс жил бүрийн 2-р улиралд нүүдлийн амбулаториор хөдөөгийн багуудад ажиллаж 536 хүнийг үзлэг шинжилгээ оношлогоонд хамруулж өвчлөл илэрсэн 402 хүнийг эмчлэн эрүүлжүүлсэн байна. Хүрч үйлчлэх арга хэмжээнд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 600.0 мян төг зарцуулсан.	Б-100
	14	-Суманд алсын зайн оношлогоо, сургалтын тогтолцоог өргөжүүлж, гар утсанд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээний шинэ			2018 онд аймгийн нэгдсэн эмнэлэгтэй утасны FACEBOOK интернэтээр 3 удаа холбогдон төрсний дараа умай урваж гарсан эх, 0-2 сартай 2	ХШ-70

		хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.			нярай уушгины хүнд хатгалгаагаар хүндэрснийг нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйүүдийн эмч, хүүхдийн нарийн мэргэжлийн эмч нарын зөвөлгөө авч цаг алдалгүй эмч нарын баг дуудаж эмчилгээ үйлчилгээ авсан. 2, 3-р шатлалын эмнэлэгээс эрүүл мэндийн зайн оношилгоонд хамрагдсанаар хүнд өвчтөнд цаг алдалгүй тусламж үзүүлэх үйл ажиллагааг судалж үе шаттай хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна.	
	15	-ЭМТ-ийн түргэний машинд засвар үйлчилгээ хийж ашиглалтыг сайжруулах, цаашип парк шинэчлэлийг хийж өвчтөнг хэвтээгээр тээвэрлэх боломжийг бүрдүүлнэ.			УИХ гишүүний багцаас шинэ түргэн тусламжийн пургон машинтай болсон.	Б-100
	16	"Эх хүүхдийг эрсдлээс хамгаалах" хөтөлбөр хэрэгжүүлнэ			Эх хүүхдийн эрсдэлээс хамгаалах хөтөлбөртэй хөтөлбөрийн хэрэгжилт 85,5%- тай байна. /Хөтөлбөрийн хэрэгжилт тусдаа гарсан./	ХШ-70
5. Сумын ЭМТ-ийн хүний нөөц, санхүүжилт, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлж бүтэц зохион байгуулалтыг шинэчлэнэ						
	17	-Эмнэлэг, эмийн сангийн барилга байгууламж, багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэл засвар үйлчилгээг үе шаттай хэрэгжүүлнэ.			Сумын орон нутгийн хөгжлийн сангаас угаалгын байр шинээр бариулахад 10сая төгрөгийн төсвийг шийдүүлсэн,5х12м2 хэмжээтэй палкан байшин баригдсан боловч засварын ажил хүлээгдээд одоогоор ашиглалтанд ороогүй байна.Барилгын ажил торх нь өрөгдөөд зогссон. 2019 онд ОНХС-н хөрөнгөөр хийж гүйцэтгэх болсон.2019 онд туркийн тика-н олон улсын байгууллагаас эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах үүднээс 10 нэр төрлийн шинжилгээ оношлогооны тоног төхөөрөмж авах төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна.	ХШ-70
	18	-Багийн эмчийн байрыг ашиглалтанд оруулж, морь, мотоциклоор хангах арга хэмжээ авна.			Багийн эмч нар ажлын байртай болсон. Багийн 2 эмчийг мотоциклоор хангаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.	ХШ-40
	19	-Их эмч, мэргэжилтний нөөцийг бүрдүүлж, сургалтанд хамруулан тогтвортой ажиллуулах бодлого баримтална.			2016 онд сумын засаг дарга, ерөнхий эмчтэй гэрээ байгуулан ЭХЭМҮТ-д 2 жил эмэгтэйчүүдийн нарийн мэргэжил эзэмших сургалтанд хамруулсан.	Б-100
	20	-Эмнэлэгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлагын сайруулж үр дүнг тооцон ажиллана.			2014-2018 онд Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын ёс зүй харилцаа хандлагыг сайжруулах аймгийн хөтөлбөртэй уялдуулан үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хариуцлага, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлж ажиллахад биелэлт 85%-тай хэрэгжсэн. Мөн ёс зүйн багийн төлөвлөгөө гарган биелэлтийг тооцсон.	ХШ-70
Хоёр.Боловсрол, соёл						
1.Хөгжлийн бодлого төлөвлөлт, менежментийг сайжруулж,салбарын хүний нөөцийг чадавхжуулна						
	21	-Мэдээллийн технологид суурилсан "Цахим зайн сургалтын төв"-тэй болж мэдээлэл солилцох, харилцан суралцах			БСШУЯ-аас нийлүүлсэн интернет төхөөрөмж, камер, виртуал самбар зэргийг ашиглан 2018-2019 хичээлийн жилд дотоод сүлжээнд холбогдсон	ХШ-70

						бүтэн жилийн хугацаанд хичээлүүлж бүс аймгийн олимпиадаас сурагчид алт мөнгө, хүрэл медаль хүртэж бүсийн сургуулийн хэмжээнд сэтгэх чадвараа тэргүүн байр эзэлж байна. □ Бүсийн хамтын ажиллагааны хүрээнд багш нарын мэргэжлийн онол, стандартын шалгалтыг зохион байгуулж судалгаа үнэлгээ хийлээ. Энэ үйл ажиллагаанд манай сургуулиас стандартаараа 6 багш, мэргэжлийн аваргаар 7 багш, хөтөлбөр боловсруулалтаар 3 багш, заах арга зүйгээр 6 багш шалгаран дараагийн шатанд амжилттай оролцсон.	
	22	-“Экологийн боловсрол”, “Оюуны спорт” зэрэгт холбогдох халх, буриад, урианхай ястнуудын ёс заншил, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.				□ Экологийн боловсрол олгох ажлын хүрээнд: Хүүхдийн оролцооны байгууллагууд “Эко” клуб, Скаутын бүлгүүд ажлын төлөвлөлт гарган үйл ажиллагаагаа явуулж байна. Төвийн бүсийн “Бид нэг гэртэй “цугларалтанд Хөвсгөл аймгийг төлөөлөн оролцсон . Скаутын 3-н сурагч дадал чадварын шалгалтыг өгч 5-н тэмдэгтийг хамгаалж хүрэл сумны болзол хангасан. Хүн орчин , иргэний боловсрол хичээл, хүүхдийн оролцооны байгууллагууд, 3-н дадал зэргээр дамжуулан хүүхэд өсвөр үеийнхэнд экологийн боловсрол ба сургууль, анги, танхимд цэцэг, жимсний бут тарих ногоон орчныг бий болгох түүнийгээ хайрлан хамгаалах аяныг хавар намар өрнүүлэн ажиллаж байна. Сургуулийн аварга шалгаруулах шатрын тэмцээнийг 4 насны ангиллалаар зохион байгуулж шилдгүүдийг тодруулж ивээн тэтгэгчдийн хандиваар шагналын санг бүрдүүлж амжилтын баяраар шагнаж урамшуулсан. Энэ тэмцээнд нийт 50 хүүхэд оролцсон. Шатрын дугуйланд нийт 24 хүүхэд хамрагдаж ААШ-д Б.Наранпунцаг мөнгөн медаль хүртсэн. Сумын ИТХ-ын дэмжлэгтэйгээр сар бүр зохиогддог ахмад шатарчдын нэрэмжит болон тэмдэглэлт баяруудыг тохиолдуулан зохион байгуулдаг шатрын тэмцээнээс сонгон секцний хүүхдүүд амжилттай оролцдог. 10а ангийн сурагч Г.Ган-Эрдэнэ өсөх ирээдүйтэй тамирчин буюу тусгай байрыг удаа дараа эзэлсэн байна. “Шатар”-ын дугуйлангийн чиглүүлэгч багш Б.Баасандорж өөрийн даасан анги буюу 6б анги нь ангиараа шатарчин болох хөдөлгөөн өрнүүлэн хичээллэж байна. 2019-2020 оны хичээлийн жилд аймгийн аварга шалгаруулах	ХШ-70

		үндсэн дээр багш нарын мэргэжлийн түвшинг дээшлүүлнэ.				интернет кафег нээн ажлуулж багш сургачид интернет орчинд ажиллах боломж бүрдсэн. 1. Энэ интернэт кафед түшиглэн бүсийн түшиц сургуулиас зохион байгуулсан газар зүйн онлайн олимпиадад амжилттай оролцож онлайнаар сургалт авах, шалгалтанд оролцох, судалгаанд хамрагдах боломж бололцоотой боллоо. 2018-2019 оны хичээлийн жилд Монгол хэл бичгийн ЭЕШ-д бэлтгэх онлайн сургалтыг 3 удаа, захирал эрхлэгчдын онлайн хурал 1 удаа, бага ангийн багш нарын сайжруулсан хөтөлбөрийн талаарх онлайн сургалт 2 удаа хими биологи англи хэлний онлайн олимпиадыг БСУГ-тай хамтран зохион байгууллаа. ❑ 2018 онд Суурь боловсролын чанарыг ахиулахад мэдээлэл харилцааны технологийг оновчтой ашиглах нь сургалтанд 3 багш хамрагдаж энэ сургалтаа сургуулийн түвшинд 3 удаа явуулж хамтран хөгжиж байна. ❑ Боловсролын мэдээллийн системд багш сурагчдын мэдээлэл төдийгүй багшийн журналын мэдээллийг бүрэн оруулж сурагчид эцэг эхчүүд ирц, дүн, багшийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авах боломж бүрдсэн. ❑ Багш нар өөрийн мэргэжлийн онцлогт тохирсон олон төрлийн программыг ажилдаа болон хичээл сургалтандаа хэрэглэж хэвшсэнээр ээлжит хичээлийн бэлтгэл сайжирч сургалтын чанарт ахиц гарч байна ❑ БМДИ-ийн эхний болон 5,10 жилийн сургалтанд багш нараа бүрэн хамруулж ажилласны үр дүнд багш нарын мэдээлэл харилцааны чадвар сайжирч байна. ❑ 2018 онд аймаг улсын 16 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 32 хүн хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн. Үүний үр дүнд 2019-оны аймгийн олимпиадаас 1 багш 1 сурагч бүсийн олимпиадаас 11 багш медальт байранд шалгарч мэргэжилээрээ тэргүүлж байна. ❑ Бага боловсролын багш бүр, дундын математикийн багш нар IQ-ын дугуйлан	
--	--	---	--	--	--	--	--

					шатрын тэмцээнд Б.Баасандорж багш дасгалжуулагч 25 баг бүрэлдэхүүнтэйгээр оролцон 6 насны ангилалаар оролцож аймгийн хэмжээнд 6 байр, хөдөөгийн сумдаас 3 байрыг тус тус эзэлж амжилт гаргасан.Б.Наранпунцаг 2 байр мөнгөн медаль , тусгай байр 1 , 5-р байрыг 1 сурагч тус тус эзэлсэн амжилт үзүүлсэн. “Даам”-ны дугуйланд 45 хүүхэд хамрагдаж 7 хоногт 4-н цагаар, 2 насны ангилалаар хичээллэж байна. Чандмань бүсийн даамны аварга шалгаруулах анхдугаар тэмцээнд 91 тамирчин 4-н төрөлд оролцсон байна. Л.Отгон-Эрдэнэ багштай баг тамирчид 100, 64 гэсэн 2 төрөлд 25-н хүүхэдтэй баг оролцож 8-н сурагч 10-н багц медаль хүртэж багаараа 2-р байр эзэлсэн байна. ААШ-х тэмцээнд багаараа оролцож мөнгө хүрэл медаль хүртсэн амжилт гаргасан.	
23	-Байгалийн шинжлэлийн болон хэлний гүнзгийрүүлсэн сургалттай аймаг, улсын жишиг сургууль болгох бэлтгэл ажлыг хэрэгжүүлж эхлэнэ.				☐ Энэ зорилтын хүрээнд “Судлаач шинжээч хүүхдүүд” нэртэй байгалийн ухаан, эх хэлний төслийг амжилттай хэрэгжүүлж эх хэл болон байгалийн ухааныг сонирхон судалдаг хүүхдийн тоо нэмэгдэж байна. ☐ Хичээл үйлдвэрлэлийн зардалаас 190000 төгрөгний үнэ бүхий “Электрон жаал”-ыг худалдан авч физикийн хичээлд ашигласнаар сурагчид шинжлэн судлах арга барилд суралцаж байна. ☐ Байгалийн ухааны хичээлийн 4 кабинетийг гэрчилгээжүүлэн кабинетийн системээр хичээллүүлж үүний үр дүнд биологийн багш Д.Цэрэндаваагийн туршилттай хичээл аймгийн сайн хичээл үйл ажиллагаанд оролцон аймгийн сайн хичээлийн санд бүртгэгдлээ. ☐ Байгалийн ухааны туршилттай хичээлийн болон хэрэгцээтэй байгаа хэрэглэгдэхүүний жагсаалт судалгаа гарган сургуулийн хэмжээнд нэгтгэн төсөл хөтөлбөрт хамруулахаар ажиллаж байна. ☐ Багш нар туршилттай хичээлийн технологи, дараалал, зөвлөмж гарган ажиллаж байна. ☐ Физикийн багш М.Төгсжаргалын бэлтгэсэн сурагчид Монголын физикийн холбооноос зохион байгуулсан бүх нийтийн Физик боловсролыг дэмжих Физикийн багийн олимпиадад амжилттай оролцож тусгай байр эзэллээ ☐ STEAM сургалтыг бага боловсролын түвшинд хичээлийн хуваарьт оруулан судалсанаар	B-100

--	--	--	--

сурагчдын техник сэтгэлгээ хөгжиж энэ чиглэлээр сонирхон судлах хүүхдийн тоо нэмэгдэж аймгийн мини фестивалд амжилттай оролцсон.

- Монгол бичгийн цагаан толгойн баяр, “Үсэглэлийн хаад” Бямбажав багшийн нэрэмжит МХБ-ийн олимпиад, 9-дүгээр ангийн массын олимпиадыг жил бүр зохион байгуулж багш сурагчдаа урамшуулан ажилласны үр дүнд монгол хэлний сургалтын чанар сайжирч ЭЭШ-ийн оноогоор аймгийн дунджаас 2.8 хувиар дээшилсэн байна.
- 2018-2019 оны хичээлийн жилд БСУГ-ын газраас зохион байгуулсан сайн сурагч уншлагын наадамд 1р ангийн сурагчдын унших чадварын стандарт 49,8 үгийн дундажтай шалгагдаж САЙН СУРАГЧ хамт олон батламжийн эзэн болсон.
- Аймгийн БСУГ-аас Эрдэм-3, Эрдэм-5 анги нийтийн олимпиадыг уламжлал болгон зохион байгуулж багш Р.Одонтуяа, Г.Гүндэгмаа багш нар “ арга туршлагатай багшаар өргөмжлөгдөн шагнагдсан.
- 2018-2019 оны хичээлийн жилд Зэрэгтэй багшийн стандарт”, “Зорилтот бүлэг”тодорхойлох БСУГ-ын шалгалтад 2-р ангийн сурагчдаас унших чадварын шалгалтыг зохион байгуулан авахад Г.Хандсүрэн багштай 2а анги 92%, Л.Отгон-Эрдэнэ багштай 2б анги 82,9%, хоёр бүлгийн дундаж нь 87,5%-ийн гүйцэтгэлтэй гарсан байгаа нь сурагчдын эх хэлний чадвар сайн байгааг харуулж байна.
- Монгол бичгийн Тээгч-Түгээгч улсын уралдаан МХУЗ-ын багш нар шавь нараа амжилттай бэлтгэн оролцуулж улсын хэмжээнд А.Эрдэнэцэцэг багшийн бэлтгэсэн 9а анги улсын хэмжээнд тусгай байр эзэлсэн амжилт гаргалаа.
- Бага боловсролын багш бүр, дундын математикийн багш нар IQ-ын дугуйлан бүтэн жилийн хугацаанд хичээлүүлж бүс аймгийн олимпиадаас сурагчид алт мөнгө, хүрэл медаль хүртэж бүсийн сургуулийн хэмжээнд сэтгэх чадвараа тэргүүн байр эзэлж байна.
- Бүсийн хамтын ажиллагааны хүрээнд багш нарын мэргэжлийн онол, стандартын шалгалтыг зохион байгуулж судалгаа үнэлгээ хийлээ. Энэ үйл ажиллагаанд манай сургуулиас

					стандартаараа 6 багш, мэргэжлийн аваргаар 7 багш, хөтөлбөр боловсруулалтаар 3 багш, заах арга зүйгээр 6 багш шалгаран дараагийн шатанд амжилттай оролцсон. □	
24	-Багш нарын 60 хувийг магистр зэрэгтэй болгон доктор, докторант багшийн тоог нэмэгдүүлж, гадаад дотоодын сургуулиудтай багш, сурагч солилцоо хийнэ.				Нийт багш удирдах ажилтны 20 хувь нь магистр зэрэгтэй болж судалгаа шинжилгээ хийх арга зүйд суралцаж байна. □ 2005 онд багш М.Төгсжаргал "Аналогийн аргыг ЕБС-ийн физик сургалтанд хэрэглэх асуудал" сэдвээр боловсрол судлалын магистр □ 2010 онд н/а Н.Тунгалаг "Эрсдэл дэх хүүхэдтэй ажиллах нийгмийн ажил" сэдвээр боловсрол судлалын магистр □ 2015 онд багш М.Анхжаргал "Химийн хичээлийн заах аргыг боловсронгуй болгох прагматик хандлага" сэдвээр боловсрол судлалын магистр □ 2015 онд багш Л.Түмэн-Өлзий "ЕБС-ийн багшийн хөгжлийн тулгамдсан асуудлууд" сэдвээр боловсрол судлалын магистр □ 2016 онд багш Д.Содномпил "Бага ангийн сурагчдын бүтээлчээр унших чадварыг хөгжүүлэх нь" сэдвээр боловсрол судлалын магистр □ 2017 онд багш Л.Отгон-Эрдэнэ "Технологийн хичээлээр сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга зүй" сэдвээр боловсрол судлалын магистр □ Математикийн багш Б.Шишгэдмаа нь "Багшийн хөгжихүйн үндэс" сэдвээр боловсролын магистрээр төгссөн./2018 онд/ □ Мэдээлэл технологийн багш Б.Энхжаргал нь МУБИС-ийн магистарт мэргэжлээрээ Багш солилцооны хүрээнд 2017-2018 оны хичээлийн жилд 2 багш Чандмань-Өндөр, Эрдэнэбулган сургууль дээр, 2018-2019 оны хичээлийн жилд 1 багш Нутгийн аваргууд, Эрдмийн далай сургууль дээр ажиллаж харилцан туршлага судалсан.	ХШ-70
25	-Багшийн шинэ санаа, арга туршлагыг үнэлэх, түгээн дэлгэрүүлэх ажиллагааг журамлан мөрдүүлнэ.				Сургуулийн түвшинд багшийн шинэ санаа арга туршлагыг үнэлэх, түгээн дэлгэрүүлэх ажлыг журамлан мөрдөж эхлээд байна. □ Энэ ажлын хүрээнд 2018 онд "Оны шилдэг багш", "Оны оюунлаг багш", "Оны арга зүйч багш" шалгаруулах журам, ЭЕШ-ын дүнгээр хамгийн өндөр гүйцэтгэлтэй багш сурагчдыг шалгаруулан ИТХ-аас шагнуулж	Б-100

--	--	--	--

багшийн хөгжлийг дэмжин урамшуулах замаар сургалтын чанарт нөлөөлж байна.

- 2018-2019 оны хичээлийн жилд сургуулийн "сайн арга технологийг шалгаруулах журам" "Шавийн хайртай багш" шалгаруулах журам гарган улирал бүр судалгаа авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

- 2018-2019 оны хичээлийн жилийн эхэнд" Ээлжит хичээлийн бэлтгэлийг сайжруулах нь" сэдвээр эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж багш нарын ээлжит хичээлийн бэлтгэлд голлон анхаарч ажилласны үр дүнд Чандмань бүсийн сайн хичээл үйл ажиллагаанд амжилттай оролцон 6 багш бүсдээ тэргүүлэн 2 багш аймгийн сайн хичээл үйл ажиллагаанд оролцон аймгийн сайн хичээлийн санд 2 хичээл бүртгүүлээ./Биологийн багш Д.Цэрэндаваагийн Навчны гадаад дотоод бүтэц сэдэвт хичээл, англи хэлний багш Х.Ундармаагийн анги удирдах урлаг сэдэвт хичээл аймгийн сайн хичээлийн санд бүртгэгдлээ/
- Бүсийн сайн хөтөлбөрийн уралдаанд 3 багшийн хөтөлбөр шалгаран залуу багш нарын хийж бүтээх хандлагад ахиц дэвшил гарсаар байна. Мөн багш нар ээлжит хичээл сургалтандаа мэдээлэл харилцааны технологийг ашиглах, багаар ажиллах чадварт ахиц гарч байна.
- Дунд ахлах ангийн хүрээнд "Тест боловсруулах явцдаа хөгжих нь сэдэвт арга зүй технологийг туршин хэрэгжүүлж эхлээд байна.
- Аймгийн боловсролын хөгжлийн технологийн санд бага боловсролын багш Г.Хандсүрэнгийн " Бага ангийн сурагчдыг хоцрогдолгүй хурдан уншуулж сургах арга зүй, бага боловсролын сургалтын менежер Л.Түмэн-Өлзийгийн" Гэрийн номын сан байгуулж багш бие даан хөгжих нь" бага боловсролын багш С.Ундармаагийн " Онолын мэдлэгийг хэрэглээ болгох нь" бага боловсролын багш Д.Мөнхжаргалын " Шүлгээр өөрийгөө илэрхийлэх нь" , МХУЗ-ын багш Ж.Цолмонгийн " Сурагчдын хэвлэл гаргах явцдаа хүүхдийн оролцооны байгууллагыг хөгжүүлэн түүгээр дамжуулан олон нийтийн оролцоо хандлагад нөлөөлөх нь", Хөгжмийн багш Д.Бэхжаргалын " Нутгийн ардын дуу, бүжгээр дамжуулан хүүхэд бүрийн дуулах, хөгжимдөх, бүжиглэх, чадварыг хөгжүүлэх нь" биеийн тамирын багш Л.Баттүвшингийн " БДБ-

					ын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй-2 " Монгол хэлний багш Г.Мөнгөнзулын " Шалтгаан ба үр дагавар " сэдэвт монгол хэлний хичээлийг, Дизайн технологийн багш Н.Саруулсайханы " Эсгий урлал" сургалтын технологийг сургуулийн сайн арга зүйн санд бүртгэн аймгийн технологийн санд хүргүүлсэн.	
26	- 150 хүүхдийн дотуур байрыг шинээр барьж, хүүхдүүдэд сурч хөгжих, эрүүл, аюулгүй нөхцөлтэй, ээлтэй орчин бүрдүүлнэ.				УИХ-ын гишүүн, ЗГ-ын гишүүн, эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн санаачлан 2019 онд тэрбум 600 сая төгрөгний төсөвтэй 100 хүүхдийн ортой сургуулийн дотуур байрны барилгын суурийг цутгах, бетон арматурын ажил эхлээд байна. Сурагчдын ая тухтай,эрүүл аюулгүй,орчин нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа.Үүнд: ☐ Эцэг эхчүүд нэг тасагт 35,000-365,000 төгрөгний засвар тохижилтыг хийлээ. ☐ Багш, жижүүр энэхүү орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд хувийн зүгээс 345,000 төгрөгний хөрөнгө оруулалтыг хийлээ. ☐ Хувиараа бизнес эрхлэгч Наранцэцэг дотуур байрны сурагчдын хэрэгцээнд Жимбилын суурийн утас хандивлалаа. ☐ Мөн дотуур байрны үйлчлэгч Д.Сарантуяа 20,000төгрөг хандивлалаа. ☐ СЗДарга,ИТХ-ын дарга нартай "Бидний хүсэл Таны ивээл" сэдэвт уулзалт, ярилцлага зохион байгуулж сурагчдын хүссэн саналыг хүлээн авч 1,700,000 төгрөгний хөрөнгө оруулалтыг хийлээ ☐ "Эцэг эхийн нэг өдөр"өдөрлөгийн арга хэмжээг жил бүр уламжлал болгон зохион байгуулж ажилладаг.. ☐ Бүсийн хэмжээнд дотуур байрын"Анхдугаар зөвлөгөөн"-ийг зохион байгуулж зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг бүсийн сургуулиудад хүргэн зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.	ХШ-70
27	-220 хүүхдийн суудалтай хичээлийн барилгыг ашиглалтанд оруулж, 2 давхар хичээлийн байранд их засвар хийнэ.				☐ 220 хүүхдийн хичээлийн байр шинээр барих ажлыг УБ хотын Ган цаг ХХК гүйцэтгэж гүйцэтгэл 85-90 орчим хувьтай байна. 11 дүгээр сарын 1 гэхэд хүлээлгэн өгөх ёстой боловч санхүүжилт / 2017 онд татагдсан 200 сая төг-ний санхүүжилт / дутуугаас барилгын ажил зогссон. 2019 оны хичээлийн жилд ашиглалтанд оруулахаар тооцож байна.	ХШ-70
28	-320 хүүхдийн хичээлийн байрны зураг төсвийг бэлэн болгоно.				Хичээлийн байрны зураг төсөв хийгдсэн. Холболтын зургийг хийлгэж байна.	ХШ-40

	29	-Сургууль, цэцэрлэгийг хөгжүүлэх сан байгуулж санхүүгийн нээлттэй ил тод үйлчилгээг хэрэгжүүлнэ.			Аймгийн Засаг даргын "Хөгжлийн хөтөч" хөтөлбөрийн дагуу сумдын сургууль, цэцэрлэгийг хөгжүүлэх сан байгуулах ажил үе шаттайгаар хийгдэж байна.	ХШ-40
2.СӨБ-ын орчинд хүүхэд бүр өөрийн онцлог, бүтээлч үйлээрээ хөгжих боломжийг бүрдүүлж цэцэрлэгийн бие даасан байдал, хамтын бүтээлч үйл ажиллагааг дэмжинэ						
	30	Цэцэрлэг өөрийн онцлогт тохирсон сургалтын бодлогоо тодорхойлж, цөм хөтөлбөрийг хүүхдийн онцлог, гарвал шинжид тулгуурлан хэрэгжүүлнэ.			Нутгийн ардын дуу, бүжиг, уламжлалт зан үйл, монгол ардын тоглоомоор дамжуулан хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх цэцэрлэгийн үзэл баримтлалттай үялдуулан сургалтын хөтөлбөрөө боловсруулж хэрэгжүүлсэн.	Б-100
	31	- Эцэг эхчүүдийн туслалцаатайгаар сургалтын ээлтэй орчинг бүрдүүлж, бүлэг бүрийг стандартын шаардлага хангасан техник хэрэгслээр хангана.			Эцэг эхтэй хамтран ажиллах хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан багш ажилчид болон эцэг эхийн төлөөлөлөөр хэлэлцүүлэн мөрдөж ажилласан. Эцэг эхийн дунд 10 үйл ажиллагаа 24 цагийн сургалт, 4 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 680 хүнийг хамруулсан. "Монгол ёс зан заншил" - аар хүүхдээ хөгжүүлэх арга зүйд залуу эцэг эхчүүдийг сургах зорилгоор Шагуйн наадам, Ардын аман зохиол, "Монгол ардын сурган хүмүүжүүлэх ухаан" Аав ээж би тэмцээн, "Хүүхэд хамгаалал" сэдэвт сургалт, "Сургамжит үлгэр" жүжигчилсэн тоглолт зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан. ЭЭЗөвлөлийн ажлыг дэмжиж эцэг эхийн зөвлөлөөс гаргасан "Хүүхдийн инээмсгэлэл-бидний аз жаргал" тоглоомын талбайн төслийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Мөн хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд төсөл хөтөлбөр боловсруулж ОНХСангаас 8.0 сая төгрөгийг шийдвэрлүүлэн тоног төхөөрөмж, бусад материалыг худалдан авч орчин нөхцөл сайжирснаар өвчлөл 15 хувь буурсан. БСШУСЯ -ны хөрөнгөөр эрхлэгч, арга зүйчийн ширээ сандал шүүгээ, 1 бүлгийн хүүхдийн ширээ, сандал хувцасны шүүгээ, шарах шүүгээ нийт 2699942 төгрөг, хандиваар 1 бүлгийн тохижилт 5 сая төгрөгний нийт 7.699.942 төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн. Уурын зуухны хүйтэн халуун усны шахуурга худалдан авах 470.0 төгрөгийг сумын засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж өгснөөр үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Эцэг эхийн хандиваар дунд бүлэг 360.0 төгрөгний өнгөт хэвлэгч авсан.	ХШ-100
	32	- Худалдан авах ажиллагааг боловсронгуй			Хөвсгөл аймгийн худалдан авах ажиллагааны	Б-100

		болгож хүүхдийг эрүүл аюулгүй хоол хүнсээр хангана.				албанд тендерийн материалыг хүргүүлж худалдан авах журмын зохион байгуулахад “ Наран-Шивээт” ХХК, “Хүнхэр Сарьдаг” ХХК шалгарч Орон нутагт бэлтгэгдсэн мах, сүү, цагаан идээ, жимс жимсгэнэ, талх, гурилан бүтээгдэхүүнийг нийлүүлсэн. Мөн ажилтан албан хаагчдын хүчээр байгалийн жимс, жимсгэнээр нөөц бүрдүүлэн 200 кг жимс, 250 кг варень бэлтгэж хүүхдийг амин дэмээр баялаг эрүүл аюулгүй хүнсээр хангасан.	
	33	-Цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн зураг төсвийг бэлэн болгож, 150-200 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай болгон өргөтгөл хийлгэнэ.				Япон улсын засгийн газрын “Өвсний үндэс” хөтөлбөрийн 203.0 сая төгрөгийн санхүүжилттэй барилгын өргөтгөл баригдаж ашиглалтанд оруулснаар 2 бүлгийн 50 хүүхэд хүлээн авч байна.	Б-100
3.Бага, бүрэн бус дунд, бүрэн дунд боловсролын залгамж чанарыг сайжруулан стандарт, сургалтын хөтөлбөрийг өөрийн онцлогт тохируулан хэрэгжүүлнэ							
	34	-Лабораторт түшиглэсэн сургалт явуулах орчинг бүрдүүлэх, гадаад хэлний лингофонын танхим, цахим номын сантай болж үйл ажиллагааг тогтмолжуулна.				□ Англи хэлний лингафоны танхим, цахим номын сан байгуулах төсөл хөтөлбөр хийж холбогдох газруудад хүргүүлсэн. □ Дэлхийн Хөвсгөл хөтөлбөрийн хүрээнд ажлын төлөвлөгөө гарган ажиллаж багш ажилчдын англи хэлний цуврал сургалт зохион байгуулж багш ажилчдын 58,6 хувь нь хамрагдаж байна. □ Англи хэлний багш нар онол арга зүйн мэдлэгийг сайжруулах 5 удаагийн сургалт семинарт хамрагдсан □ Бүсийн багш ажилчдын хамтын ажиллагаанд англи хэлний хэрэглээний чадварыг шалгасан сорил даалгавар оруулж багш ажилчдынхаа гадаад хэлний чадварт анхаарч байна. □ Сургууль суманд зохион байгуулагддаг аливаа үйл ажиллагааг хөтлөхөд англиар орчуулж танилцуулж хэвшсэн зэрэг ажлыг хийж багш ажилчдынхаа англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх ажил хийгдэж байна. □ Бага боловсролын багш бүр, дундын математикийн багш нар IQ-ын дугуйлан бүтэн жилийн хугацаанд хичээлүүлж бүс аймгийн олимпиадаас сурагчид алт мөнгө, хүрэл медаль хүртэж бүсийн сургуулийн хэмжээнд сэтгэх чадвараа тэргүүн байр эзэлж байна. □ Бүсийн хамтын ажиллагааны хүрээнд багш нарын мэргэжлийн онол, стандартын шалгалтыг зохион байгуулж судалгаа үнэлгээ хийлээ. Энэ үйл ажиллагаанд манай сургуулиас стандартаараа 6 багш, мэргэжлийн аваргаар 7 багш.хөтөлбөр боловсруулалтаар 3 багш, заах арга зүйгээр 6 багш шалгаран дараагийн шатанд амжилттай оролцсон.	ХШ-70

35		-Ахлах ангийн хүүхэд бүрийн авъяас сонирхолд тулгуурлан хөтөлбөрөөс давсан агуулгаар сургалт зохион байгуулж амьдрах чадвар бүхий иргэнийг төлөвшүүлнэ. / Орон нутгийн онцлогийг харгалзан загас үржүүлэг, аялал жуулчлал, мод модон бүтээгдэхүүн, МAA-н үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжлийн сургалт явуулах бэлтгэл хангаж хичээллүүлнэ/.			□ 2018-2019 хичээлийн жилд шатар, даам, гар бөмбөг, бөх, шагай, ширээний теннис, цана, тэшүүр, мэтгэлцээн, соробан сампин, сэтгэх чадвар, мэдээлэл зүй, үндэсний хөгжим, мэтгэлцээн зэрэг 20-иод төрлийн сонгон дугуйлан хичээллүүлж аймаг улсын чанартай тэмцээн уралдаанд медальт байранд шалгарсан байна. □ АМЧОБ олгох сургалтыг ахлах ангийн сурагчид тэдний эцэг эхчүүд, багш нарт цувралаар явуулж хичээл сонголтыг бодитоор хийж байна. □ ЕБС-ийн АМЧБО багш сурагч, эцэг эхчүүдийн дунд тусгай хөтөлбөр удирдамж төлөвлөгөөний дагуу товлсон цаг хугацаандаа зохион байгуулагдаж өнгөрлөө.Эцэг эхийн харилцаа хандлагад өөрчлөлт орж хүүхэд сурч хөгжихөд эцэг эхийн оролцоо, багш, эцэг, эхийн харилцаа, уялдаа холбоо чухал гэдэг нь харагдсан. Хөвсгөлөөс Улаанбатырын чиглэл 5 өдрийн “ Аялал-2019” аялалд 9 сурагч нийгмийн ажилтан 1 нийт 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр ХХҮГ-ын мэргэжил сонголт аялалд оролцлоо . □ Сонгоны хичээлээр хөтөлбөрөөс давсан агуулгаар сурагчдын ярих, мэтгэлцэх , бүтээл хийх ,төсөл хөтөлбөр хийх, ном гарын авлага программ зохиох гэх мэт чадварыг хөгжүүлж байна. □ Суурь боловсрол эзэмшсэн сурагчдын авъяас сонирхол орон нутгийн хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн чиг баримжаа олгох бүлэг нээн хичээллүүлэх ажлыг эхлүүлэх судалгаа хийгдэж байна.	ХШ-70
36		-Монгол хүний эрхэмлэх үнэт зүйл, ёс зүй, зан заншил, өв уламжлалын талаар нутгийн ахмадууд, сэхээтэн, эрдэмтэдийн оролцоотой тусгай сургалтыг хөтөлбөрийн дагуу оруулна.			ЕБС-ийн захиралын тушаалын дагуу ажлын хэсэг байгуулагдан 3,4-р улиралыг монгол наадгайг хөгжүүлэх улирал болгон удирдамж, ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Шагайн наадгай, шагайн харвааг хөгжүүлэх арга хэмжээг ЕБС-ийн багш ажилчид,сурагчид, эцэг эхчүүдийн дунд зохион байгуулсан. Монгол наадгайг хөгжүүлэх зорилтын хүрээнд зан үйлийн танхимыг 11ш тоглолтын олбог, 44ш суудлын жижиг олбог,11ш гэр, 1100ш шагай, 11ш хөө хуягаар баяжуулан 4-н насны ангилалаар 84 сурагч оролцож ангилал тус бүрд 1,2,3, байрыг шалгаруулж алт, мөнгө, хүрэл медалиар шагнаж	ХШ-70

					урамшуулсан. Сумын аварга шалгаруулах “Шагай шүүрэх” тэмцээнийг баг, байгууллагын дунд зохион байгуулж 7 багийн 28 хүн оролцож шилдгүүдийг тодруулсан. Монголын уламжлалт баяр Цагаан сарыг тохиолдуулан багш, ажилчдын дунд уг тэмцээнийг зохион байгуулж ахуй соёлыг түгээн дэлгэрүүлсэн. Анги танхим болон сургуулийн орчин мэдээллийн орчинд “Шагайн наадгайн чиглэлээр мэдээлэл зураг үзүүлэн, материал гарын авлага бэлтгэн тавьж ухуулга сурталчилгаа хийсэн. 2018-2019 оны хичээлийн жилийн уламжлалт ажлын графикт Дээлтэй Монгол, Зөв монгол хүүхэд 14 хоногийн аян, Шагайн наадгай, Шагайн харваа, Хуурнин шуугих бөхийн барилдаан, дуулах өв наадам, үйл ажиллагаагаар дамжуулан хүүхэд өсвөр үеийнхэнд боловсрол олгож байна. Сурагчдын дунд шагайн харвааны дугуйлан хичээлүүлж сумын аварга шалгаруулах шагайн тэмцээнд Отгонбаяр дасгалжуулагчтай баг аваргаар шалгарсан төдийгүй сурагчид уламжлалт шагайн наадгайг сонирхон хичээлэх нь нэмэгдэж байна. Хуурнин шуугих бөхийн барилдааныг сар бүр зохион байгуулж хэвшсэн төдийгүй эцэг эхийн оролцоо дэмжлэг нэмэгдсэн.	
4. Иргэдийн насан туршид суралцах хэрэгцээ, сонирхол, авъяас, чадвар онцлогт нийцсэн хувилбарт хөтөлбөрөөр үйлчилгээ үзүүлнэ.						
	37	-Бүрэн дунд боловсрол эзэмшигч нэг бүрт мэдээлэл харилцаа холбооны ба дэвшилтэт техник технологиор харьцан ажиллах чадвартай болгоно.			Ерөнхий боловсролын сургуулийн 10,11-р ангийн сурагчдад “Мэргэжил сонголт”сэдвээр сургалт хэлэлцүүлэг хийсэн. Сургалтыг аймгаас ирсэн сургагч багштай хамтран явуулсан. Сургалтанд 70 сурагч хамрагдсан.6-12р ангийн сурагчдад “Мэндлэх хүндлэх монгол ёс” сэдэвтэй сургалт орж гарын авлага тараасан.Мөн сурагчдын дунд хуримтлалын клуб хичээлүүлж байна. Клуб нийт 25 сурагчидтай.	ХШ-70
	38	-Иргэдийн нас бие, сэтгэлзүйн онцлог, сурах хэрэгцээнд зохицуулан сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж захиалгат болон цахим сургалтанд хамруулна.			НТБ- олгоход ёс суртахуун төлөвшил,амьдрах ухааны, гэр бүлийн, гоо зүйн боловсрол олгох чиглэлийг барин ажиллаж байна. Төрийн албан хаагчдад санхүүгийн боловсрол олгох сургалтыг явуулж сургалтанд нийт 100 н төрийн албан хаагчид 9-12-р ангийн 70 сурагчдад мөнгөн хуримтлал үүсгэх, өр зээл тавихгүй байхад анхаарах аргуудаас суралцсан. Монголын уламжлал “Шагайн наадгай” сум орон нутагтаа хөгжүүлэх зорилгоор сургалт үйл ажиллагаа тэмцээн уралдаан зохион байгуулсаны үр дүнд сумын хэмжээнд иргэд гэр бүл уламжлалт тоглоомоор тоглодог болж байна. Сургуулийн	ХШ-70

					хэмжээнд 10 ш шагайн тойром, 20 ш олбог, 10 ш шагайн уут хийсэн. Дүйцсэн хөтөлбөрөөр 4 сурагч хичээлүүлэн, суурь боловсрол нөхөн эзэмшүүлж, суурь боловсролын гэрчилгээ олгосон. Иргэдэд Арьс ширэн эдлэлын сургалт орж түлхүүрын оосор, үзэгний уут хийлгэж дадлагжуулсан. Сургалтанд нийт 21 хүн хамрагдсан. Санхүүгийн суурь боловсролын хүрээнд иргэд болон албан хаагчдад “Хуримтлал” сэдвээр сургалт орсон. Мөн эцэг эхчүүдэд “Хүүхдийн хүчирхийлэл” сэдвээр сургалт орж гарыг авлага тараасан. Сургалтанд нийт 25 хүн хамрагдсан. Байгууллагуудын эрэгтэй ажилтанд “Тамхины хор хөнөөл” сэдвээр сургалт сурталчилгаа хийж боршур тараасан. Дүйцсэн хөтөлбөрийн суралцагч 6 болж нэмэгдсэн байна.	
5. Соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын үнэт өвийг хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлж, өвлүүлэн хөгжүүлнэ.						
	39	-Соёлын салбарт хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.			Аймгийн соёл урлагын газрын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдаж өвийн ажилтан 2, номын санч 2, эрхлэгч 2 удаа тус тус төлөвлөгөөт сургалт семинарт хамрагдсан. “Монголын Соёлын төвүүдийн эрин холбоо”-ны анхдугаар хуралд санаачлагчдын зүгээс оролцсон байна. Мөн 6-р сард бүжгийн багш СУИС-Монголын бүжгийн холбоотой хамтарсан бүжиг заах арга зүй, бүжгийн үндсэн хөдөлгөөн дасгал зэрэг анхан шатны мэдлэг олгох сертификаттай 7 хоногийн сургалтанд УБ-хотод суусан. Номын санч СУИС-ын Соёлын сургуульд номын санчийн мэргэжлээр үлдсэн кредит цагийн хичээлдээ 21 хоног суусан хавар төгсөнө.	ХШ-70
	40	-Буриад, урианхай ястны соёлын өвийг хадгалах, хөгжүүлэх сан бий болгоно.			Соёлын төвийн бүртгэл мэдээллийн санд СББӨ-ийг өвлөн уламжлагч 26 ардын авьяастны мэдээллийг санд /Маягт-3/ бүртгэж байна. Нутгийн ардын урианхай дуу 8, буриад дуу 5, нутгийн холбогдолтой /зохиолын/ дуу -3 бүртгэн баримтжуулж мэдээллийн санд орууллаа. Цаашид ном гаргах, хуурцагт хуулах /понаграмм хийх, хоолой бичүүлэх/ ажлуудыг төлөвлөсөн байна. Нутгийн холбогдолтой уул, ус, нутаг, мал сүргийн тухай, ард түмний ам дамжиж ирсэн бөхийн тухай домог, хууч яриаг баримт болгон 30 ахмадаас цуглуулж хадгалж байна. МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга асан П.Цагааны эрхлэн хэвлүүлсэн “Буриад дууны цоморлог”, номонд нутгийн буриад түмний дунд дуулагддаг “Бууралхан Бургалтай” “Ерэхэ яагааш”	ХШ-70

					“Тийгэнэ гээ гүү” зэрэг дуунуудыг орууллаа. Даваадамдингын шүлэг “Хоймор нутгийн соёл” дууны хоолой бичлэгт хөвсгөлийн дуучидтай хамтран өвийн ажилтан дуулж оролцлоо. Нутгийн буриад ард түмний төлөөлөл болон “Алунгоо эхийн үр сад” язгуур урлагийн наадам, “Нүүдэлчин Монгол” өв соёлын их наадмуудад амжилттай оролцсон. Нутгийн ардын дууны урын санг баяжуулах зорилгоор ахмад авьяастнуудаас өвлөн суралцах шавь сургалтыг эхлүүлсэн байн Мөн нутгийн ардын 20 дууг өвлөн уламжилж яваа ардын авьяастнуудаар дуулуулан хураан авч бүртгэл мэдээллийн сандаа хадгалсан ба БСУГ-т хүгүүлсэн.	
	41	-Нийтийн номын сангийн фондыг нэмэгдүүлэн цахим сан байгуулж, интернетэд холбоно.			БСШУЯ-аас 1.000.000 төгрөгний хөрөнгө оруулалт хийгдэх ба шинэ номын сэлбэлт хийгдсэн бөгөөд номыг 100 хувь цахим программд бүртгэлээр оруулсан байна. Соёлын төвийн нийтийн номын сан нь 2015 оноос Монбибли програмд номоо оруулж эхэлснээр 2018 оны байдлаар нийт 900 ном оруулсан байна. Нийт номонд бар код хэвлэж наах зэрэг ажлуудыг хийсэн.	ХШ-40
	42	-Орон нутаг сурталчлах танхим,музей байгуулна.			Орон нутгийн холбогдолтой түүхэн баримт, материал, угсаатны эдэлж хэрэглэж ирсэн эд өлгийн зүйлийг цуглуулан хадгалах, сурталчлах зорилгоор үзмэр гаргаж ОНСТ-ийг үүсгэн байгуулж эхлүүлсэнээр одоогоор 30 ширхэг эд өлгийн дурсгалт зүйлсийг иргэдийн гар дээрээс цуглуулсан байна.	ХШ-40
	43	-Иргэдийн санаачлагаар зохион байгуулагдаж буй ургийн баярыг дэмжин ач холбогдлыг нэмэгдүүлж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ.			Язгуур өв соёлоо хадгалж үлдэх зорилгоор “Мормоонтон” “Дархан Чойдовтон”ий буриад түмний ургийн баяр, “нээр сохих” наадаан, “ Даян Дээрхийн цом” үндэсний шагайн тойром, “Буриад бөх”ийн барилдаан зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж “Буриадын урлаг, соёл”-ыг дүгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж ирсэн. Угийн бичиг хөтлүүлэх орон нутгийн сургагч багш бэлтгэх сургалтанд хамрагдаж 15 ахмадад угийн бичиг хөтлөх сургалт зохион байгуулж хөтлөх аргачлалыг эзэмшүүлсэн байна. Сонсгол мэдээллийн цагаар төрийн албан хаагчдад угийн бичиг хөтлөх сургалт мэдээлэл өгөв.”Хамбынхан” “Галсангийнхан” ургийн ном хэвлэгдэж 400 гаруй өрхөд тараагдсан байна. Нийт 2000 гаруй иргэдийн ургийн зурлага багтсан бичиглэлийг, хөтөлсөн өрхийн бүртгэлд орууллаа. Мөн Хасын ахан дүүсийн баяр, Үлүүшигтэн, Тариачновтон буриад ахан дүүсийн ургийн баяр, Дашийн ахан дүүсийн баяр, Далайцэрэнгийн алдар тэмдэглэх ахан дүүсийн баярууд тус тус зохион	Б-100

					байгуулагдав.	
44	-Орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй болно.				Хөрөнгө санхүүгийн эх үүсвэргүйгээс хугацаа хойшилсон боловч "Хөвсгөл" ард түмний телевизтэй гэрээ байгуулах хамтран ажиллаж байна. Монголын цагаан сарын баярыг угтсан "Сар шинийн мэнд" нэвтрүүлгийг "Хөвсгөл ард түмний" телевизтэй хамтран зохион байгууллаа. Үүнд ардын авьяастнуудын язгуур урлагийн тоглолт, тоглолтонд 3 ястны дуу, бүжиг, иргэд, төрийн албан хаагчдын дунд "Таван эрдэнэ" өв уламжлал, ёс заншилтай холбоотой цэнгээнт уралдаант нэвтрүүлгийг явуулсан байна. -Улсын их баяр наадам, өв уламжлал, ёс заншлаас иргэдэд өвлүүлэн үлдээх, сурган хүмүүжүүлэх, тухайн жилийн сум орон нутгийн онцлог, үндэсний бөх, сурын харваа, хурдан ажнай хөлгүүдийн талаар бахархан дуурсах, сурталчлан таниулах зорилгоор "Наадмын үдэш" цэнгээнт нэвтрүүлгийг Хөвсгөл ард түмний телевизтэй хамтран явууллаа. Байгалийн үзэсгэлэнт газар нутагт зураг авалт хийгдэж, нутгийн онцлогтой буриад, урианхай үндэстний урлаг, соёлоос "Мэнд амор Алтаргана" "Айлшлуулаарай" "Бөхийн эх орон" бусад нийтлэг монгол ардын дуунуудаас дуулж, нутгийн бахархал болсон уул, усны домог, алдарт бөхчүүдийн түүх, уяачдын эрдэм зэрэг өв соёлоо сурталчилсан сайхан нэвтрүүлгийг бэлтгэж didsh-ийн 71-р суваг, Юнивишний 939-р суваг, Молор ND суваг, TV-9 телевизээр улс даяар гаргасан байна. Мөн Даян Дээрх, Суварга хан уул, Цагаан бурхан гурван хайрханы хишиг бэсрэг наадам, Даян Дээрхийн цом шагайн тойром зэрэг баяруудаар Хөвсгөл ард түмний ТВ-тэй хамтран ажиллаж төрийн алба болон сумын бүтээн байгуулалт цаг үеийн асуудлаар мэдээлэл өгсөн.	ХШ-40
45	-Соёлын төвийн техник хэрэгсэл, урлагийн хувцсыг үе шаттай сайжруулна.				БСШУСЯ-ны 2019 оны хөрөнгө оруулалтын захиалгад соёлын төвийн техник тоног төхөөрөмжийн захиалгыг өгсөн бөгөөд энэ онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 10.0 сая төгрөгөөр техник хэрэгсэл, гэрэлтүүлэг авсан.	Б-100
46	-Урлаг соёлын алдартнуудыг дэмжих, алдаршуулах ажиллагаа явуулна.				Сумын хэмжээнд соёл урлагын чиглэлээр амжилт гаргасан иргэдийг алдаршуулах ажлыг судлаж байна.	ХШ-40
47	-Даян Дээрхийн 6 харуулын уугуул нутгийнхны "Эв модны наадам"-ыг 2 жилд зохион байгуулна. Даян Дээрхийг төрийн тахилгатай болгох саналыг холбогдох газарт				6 харуулын "Эв модны наадам"-ын суурь эхлэл болгон Даян дээрхийн цом, Суврага ханы хишиг наадмыг 2019 онд зохион байгуулсан.	ХШ-40

		тавьж шийдвэрлүүлнэ.					
	48	- Уялган 3 аварга цогцолбор, Дархинтын Сартолгойн тэнхим байсан газарт номын гэрэлт хөшөө босгож нутгийн уугуул ястаныхаа соёл зан үйлийг сурталчилсан эд өлгийн зүйл, фото зургаар үзмэрүүд бэлтгэж аялал жуулчлалын эвент болгоно.				Хавсгал аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөнд тусгагдаж	ХШ-40
Гурав.Хүүхэд, гэр бүл Гэр бүлд суурилсан хөгжих, оролцох, хамгаалах эрхийг ханган хүүхдэд ээлтэй сум болно.							
	49	-Сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж хүүхдэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг бий болгож, тэдэнд зориулсан дэд бүтцийг сайжруулах замаар хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлнэ.				Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах тэдэнд тулгамдсан асуудлыг бодлогын баримт бичигт тусгах ажлыг шат дараатай зохион байгуулж байна. 1. Энэ онд Хүүхэд хамгаалалын чиглэлээр эх хүүхдийг эрсдлээс хамгаалах үйл ажиллагаанд 2018 оны ОНХ сангийн 550.0 мянган төгрөгний хөрөнгө оруулалтаар цагдаагийн кабонд "Хүчирхийллийн эсрэг төв" –ийн байр гарган тохижуулж үйл ажиллагааг тогтмолжуулах зорилт тавин ажиллаж байна. 2. Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламж "Өвсний үндэс" хөтөлбөрийн "198.0сая төгрөгний санхүүжилтээр 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөл баригдаж 100%-ийн гүйцэтгэлтэй хүлээн авлаа. 3. 2019 оны ОНХ сангийн 30.0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар ЕБСургуульд пургон авто машин нийлүүлэв. 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тэрбум 600 сая төгрөгөөр "Хөх тэнгэр Хөвсгөл" ХХК ЕБСургууль дотуур байрны ажлыг гүйцэтгэхээр үйл ажиллагаа эхэлсэн. 5.Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2.313.700 төгрөг зарцуулж сумын төвийг нийтэд нь хянах хүчин чадалтай камер суурилуулж "Нью феир Инженеринг" ХХК гүйцэтгэн хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлхээр ажиллаж байна.	Б-100
	50	-Гэр бүл, хүүхдийн цогц хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхэд, гэр бүлд чиглэсэн хөгжил, хамгааллын үйлчилгээний хүрээ, нэр төрлийг нэмэгдүүлэн чанартай шуурхай үйлчилгээг бүх талаар дэмжин өргөжүүлнэ.				Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр шинээр батлагдсан хуулиудыг сурталчлах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчил дутагдлыг шалтгаан нөхцлийг тодорхойлж хариу арга хэмжээ авах зэрэг арга хэмжээг зохион байгуулах хамтарсан багийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Хүүхэд хамгаалал өрхийн аюулгүй байдал" аяныг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/72 дугаар захирамжаар байгуулсан. Аяныг	ХШ-70

					зохион байгуулах төлөвлөгөө гарган ажилласан бөгөөд эрсдлийн үнэлгээнд хамрагдах 778 өрхөөс 597 өрхийг хамруулсан бөгөөд давхардсан өрх, орон нутагтаа байнга оршин суудаггүй болон эзэнгүй байсан 181 өрх хамрагдаагүй байна. Судалгаанд хамрагдсан өрхийн үнэлгээнээс дүгнэж үзэхэд сумын түвшинд өндөр эрсдэлтэй байсан 3 асуудлыг энэ онд шийдвэрлэж байна. 1. 2020 онд Сумын төвийн гэрэлтүүлэгийг Аймгийн орон нутгийн төсвийн /100.0 сая төгрөгөөр/ засварлаж шийдвэрлэх шатандаа явж байна. 2. Байгаль хамгаалах сангаас золбин нохой устгалд 741.0 мянган төгрөгийг зарцуулж дөрвөн багаас 80 нохой устгасан байна. 3. Угийн бичиг хөтлөлт сумын хэмжээнд нийт өрхийн 70% нь хөтөлж байна. Мөн 2019 оныг "Хүүхэд хамгаалах, өрхийн хөгжлийг дэмжих" нэрлэсэн жилийн хүрээнд 6 зорилт 58 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд 74% -тай хэрэгжүүлсэн байна.	
	51	-Хүүхдийн төлөө санг бүрдүүлэх, төсөв, хөрөнгө оруулалтаар дэмжих арга туршлагыг судалж дэлгэрүүлэх замаар хүүхэд төвтэй гэр бүл, олон нийт, төр, хувийн хэвшлийн харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлнэ.			Хүүхдийн төлөө сан байгуулах судалгааны ажил хийгдэж байна.	ХШ-40
	52	-Гэр бүлд уламжлалт соёл, зан заншлыг хадгалан өвлүүлэх,хөгжүүлэх орчинг бүрдүүлж зөвлөгөө өгөх төвийг нээн ажиллуулна.			"Өв соёлоо дээдлэе" уламжлалт соёл, зан заншлыг хадгалан өвлүүлэх, хөгжүүлэх талаарх урлагийн тоглолтонд бэлтгэл бүлгийн 40 хүүхэд, 18 эцэг эх оролцолоо. Үүнд өөрийн орон нутагт байгаа үндэстэн ястаны өв уламжлал үлгэр домог 2, шинээр 2 дуу, 3 шүлэг зааж бусдадаа түгээн дэлгэрүүлж нийт 150 хүнийг хамруулсан байна. Мөн гэр бүлд зөвлөгөө өгөх ажлыг "Хүчирхийллийн эсрэг төв" дээр хуваарь гарган сум, сургууль, ЭМТ-ийн нийгмийн ажилтнуудад ажиллаж байна.	ХШ-70
Дөрөв.Хөдөлмөр эрхлэлт 1. Ажиллах хүчнийг чадваржуулах, дадлагажуулах, хөгжүүлэхэд онцгой анхаарч орон нутгийн нөөц боломжид нийцүүлэн тогтвортой ажлын байр бий болгох замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг сайжруулж, эдийн засгийн өсөлтийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.						
	53	-Иргэдийн хувиараа хөдөлмөр эрхлэж нөхөрлөл, хоршоо байгуулж ажиллахад тоног төхөөрөмж, гарааны үеийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.			Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас залуучуудын дэмжих хөтөлбөрөөр булган багийн иргэн Х.гансүх 5,0 сая төгрөгийн,Уялган багийн иргэн Х..Анхбаяр,Б.Наранбаатар нарт тус бүр 5,0 сая төгрөгийн малжуулах хөтөлбөрт хамруулж малыг нь хүлээлгэж өгсөн. Мөн Зөгийн аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлж 2 өрхөд 15 сая төгрөгийн 0,7 хувийн хүүтэй зээлийг олгосон.	ХШ-100

	54	-Хөдөлмөр эрхлэлтийн зохистой орчныг дэд бүтэц, эрчим хүч, үйлдвэрийн шугам гэх мэт бүрдүүлнэ.				Үйлдвэрийн бүсийг өрхөд тусд нь байршуулж эрчим хүчээр хангах төсөл хийгдсэн.	ХШ-100
	55	-Ажил олгогч, ажилтны нийгмийн хариуцлага, хандлагыг сайжруулж хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлнэ.				Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ААН, албан байгууллагын ажилтан албан хаагч нартай хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах талаар анхаарч хамтарсан гэрээ байгуулан ажиллаж байна.	ХШ-70
	56	-Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадварт суурилсан мэргэжлийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжинэ				ЕБСургуулийн ахлах ангийн сурагчдад мэргэжил сонголтын талаархи сургалтыг 6 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 160 сурагч хамрагдсан. Аймгийн мэргэжил үйлдвэрлэлийн сургалтын төвтэй хамтран мэргэжил сонголтын талаар сургалт сурталчилгааг нэг удаа зохион байгуулсан.	ХШ-100
Тав.Нийгмийн халамж							
1.Хүн амын өсөлтийг дэмжиж, хүний хөгжлийг хангахад чиглэсэн эдийн засаг, нийгмийн таатай нөхцлийг бүрдүүлнэ							
	57	-Төрөлтийг дэмжиж, нас баралтыг бууруулах замаар цэвэр өсөлтийг нэмэгдүүлнэ.				Төрөлт 36, нас баралт 12 байгаа нь нийт хүн амын тоотой харьцуулахад 2.2 хувийн цэвэр өсөлттэй байна.	Б-100
	58	-Орон нутагтаа ажиллаж амьдрах орчинг нөхцлийг бүрдүүлж гадагш шилжих хөдөлгөөнийг бууруулна.				Сүүлийн 2 жилийн судалгаагаар хүн амын цэвэр өсөлт тогтмол 2 хувиар нэмэгдэж байна. Суманд мод боловсруулах үйлдвэр, мах боловсруулах цех, аялал жуулчлалын отог баазууд бий болгосноор шилжих хөдөлгөөн буурна.	ХШ-70
	59	-Нийгмийн халамжийн үйлчилгээний хамрах хүрээг оновчтой тогтоож, чанар хүртээмжийг сайжруулан халамжийн хөгжлийн үйлчилгээнүүдийг түлхүү үзүүлж, бэлэнчлэх сэтгэлгээг бууруулна.				Нийт сумын хэмжээнд идэвхитэй ажил хайгч 50 иргэн бүртгэгдсэнээс 3-н ААН-д ажилгүй залуучуудыг ажилд зуучилж 50 иргэн түр ажлын байраар хангасан. Халамж хүртэгчээс баялаг бүтээгчийг бий болгох сургалтыг нэг удаа зохион байгуулж 140 ажилгүй иргэдийг хамруулсан.	Б-100
	60	-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд саадгүй оролцох боломжоор ханган, хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг дэмжин өргөжүүлнэ.				Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангах асуудлын хүрээнд булган багийн 2 иргэнд хөдөлмөр эрхлэх дэд сангаас 4.4 сая төгрөгийн зээл олгогдсон. Өрх толгойлсон хөгжлийн бэрхшээлтэй 1иргэнд арьс шир боловсруулахад 4,0 сая төгрөг,хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа 1 эхэд 400,0 мян.төгрөгийн буцалтгүй төсөлд хамруулсан.	Б-100
	61	-Дундаж орлоготой өрх, иргэнийг 2 дахин нэмэгдүүлнэ				Дундаж орлоготой өрх, иргэдийг тодорхойлох аргачлалын судалгааны ажлыг хийж 2019 оны эхний хагас жилд Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	ХШ-70

62	2.Ахмадуудад үзүүлэх халамж, хамгааллын арга хэмжээг өргөтгөн, нийгмийн оролцоог нь нэмэгдүүлэн, тэдгээрийн аж байдал, амьдралын чанарыг сайжруулна.				Нийгмийн халамжийн сангаас 61 иргэнд 99419.0 мян. төгрөгийн тэтгэвэр, байнгын асаргааны тэтгэмжид 89 иргэнд хүн 50594,1 мян. төгрөгийн тусламж хөнгөлөлт нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэнд үзүүлэх тэтгэмжинд 66 иргэнд 233163,0 мян.төгрөг,ахмад настны хөнгөлөлт тэтгэмжинд 291 иргэнд 12219,8 мян.төгрөг тус тус олгосон байна.	Б-100
63	-Ахмадуудын чийрэгжүүлэлтийн танхимын үйл ажиллагааг өргөтгөн "Чийрэгжүүлэлт, соёл гэгээрлийн төв" болгож, шинэ барилга бариулж оруулна.				Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэсээс ахмадын чийрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулж 8700000 төгрөгийн үнэ бүхий 9 тоног төхөөрөмж нийлүүлсэн. Мөн ахмадын байрны асуудлыг шийдэж тусдаа байртай болгосон.	Б-100
64	-Ахмадуудад зориулсан ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.				Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Зөвлөх багшийн 1 сарын сургалтыг "Мод тарьж арчлах " сэдвээр зохион байгуулж нэг ахмад настан 280.000 төгрөгийн цалин олгосон. Төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 2 ахмад настныг 2.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олгосон.	Б-100
65	-Ахмад настанд зориулсан эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ \ЭМТ-д тусгай тасаг,сувилалын газар бий болгоно.				Сумын ЭМТ-д ахмад настанд зориулсан тусгай тасгийг эхний хагас жилд багтаан нээхээр төлөвлөж байна. Мөн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оншилгоонд сумандаа хамруулж байна.	ХШ-70
66	-Албан байгууллагын дэргэдэх Ахмадын зөвлөл, холбоодын үйл ажиллагааг сумын ахмадын хорооны ажилтай нягт уялдуулан нэгдмэл байдлыг хангаж дэмжлэг үзүүлнэ.				Суманд үйл ажиллагаа явуулж буй төсөвт байгууллага бүр байгууллага дээрээ ахмадын зөвлөл байгуулж үйл ажиллагааг зохион байгуулж байна. Мөн сумын ахмадын хороотой үйл ажиллагаа уялдуулан зохион байгуулж хэвшсэн. Энэ онд ахмад настнаа дэмжих нэрлэсэн жилийн хүрээнд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 3,263.900 төгрөгийн санхүүжилт хийгдэж аймаг сумын ахмадын урлаг, спортын наадмын арга хэмжээнд оролцсож Чандмань-Өндөр сумын ахмадын хороотой танилцах, туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулсан.	Б-100
Б.ЭДИЙН ЗАСАГ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
Ногоон үйлдвэржилт, уламжлал шинэчлэл хосолсон хөдөө аж ахуйг хөгжүүлж, аялал жуулчлалаар дотоод, гадаадад танигдаж дэд бүтцээ хөгжлийн хурдасгуур болгосон найрсаг зочломтгой Цагаан-Үүр сум болно						
Зургаа.Санхүү, эдийн засаг						
1.Төрийн байгууллагын үйл ажиллагааг төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлж хамгийн бага зардлаар үр дүнд хүрэх бодлогыг хэрэгжүүлнэ.						
67	-Төсвийг сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан оновчтой төлөвлөн үр ашигтай зарцуулж, ил тод тайлагнах				Сумын төсвийн төслийг сумын засаг даргын хөтөлбөр болон сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан. Үүнд 2019 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 189,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг	Б-100

					төлөвлөн зохион байгуулж зарцуулалтыг үр дүнтэй гүйцэтгэж үр дүнг ил тодоор тайлагнаж ажилласан. Урсгал төсвийн төлөвлөлт бодитой оновчтой болж орлого, зарлагын тэнцэл 100 хувь, төсвийн орлого 106,6 хувиар биелсэн.	
	68	-Үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлж чанаржуулах замаар татварын бааз суурийг өргөтгөн орон нутгийн орлогыг 2016 оны түвшнээс 2 дахин нэмэгдүүлнэ.			Орон нутагт үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байгаа иргэдийг төсөл, хөтөлбөрт хамруулах, СХС-аас зээл олгох зэргээр дэмжин ажилласнаар орон нутгийн орлогын төлөвлөгөө 2016 онтой харьцуулахад 105,6 сая төгрөг болж 1,6 хувиар нэмэгдэж, татварын бааз суурь жилээс жилд тогтвортойгоор өсч байна.	Б-100
	69	-Санхүүгийн үйл ажиллагаанд үр ашигтай арга барил, туршлагыг нэвтрүүлэн хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.			Сумын төсөвт байгууллага бүрт дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах ажлын хэсгийг 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсэг 2019 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан төсвийн захирагч нараар батлуулан хэрэгжүүлж ажилласан. Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж аймгийн Санхүү аудитын албаны 5 удирдамжийн дагуу ажлын хэсэг 1. Байгууллагын дотоод хяналт 2. Тусгай сан 3. Худалдан авах ажиллагаа 4. Нийгмийн эрүүл мэндийн зардал 5. Хөгжсөн хөвсгөл хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод хяналтыг хийхээр төлөвлөсөн. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг сумын засаг даргын зөвлөлийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж зөрчил гаргасан төсвийн шууд захирагч болон нягтлан бодогч нарт сахилгын арга хэмжээг авахаар тооцоолон ажиллаж байна. Аудитын хорооны тогтоолуудыг хяналтандаа авч хэрэгжилтийг хангаж байна.	Б-100
	70	-Орон нутгийн хөгжилд гадаад дотоодын төсөл, хөтөлбөрийн хөрөнгийг татан төвлөрүүлж үр дүнтэй ажиллана.			ЕБС-ийн сургуульд БСШУСЯ-аас шинэ хичээлийн байрны тохижилтод зориулж 19823.9 мян.төгрөгийн багш сурагчийн ширээ, сандал, БСШУСЯ, дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд "СУМЫН БАГШ" хөгжлийн хөтөч сургалтын хэрэглэгдхүүн, сургалтын зардалд 12252,0 мян.төг СӨБ-д 2019 онд японы засгийн газрын "Өвсний үндэс" буцлалтгүй тусламжийн хөрөнгөөр 2 бүлгийн өргөтгөл 198000.0 мян.төг, БСШУСЯ-аас 2699.9 мян.төгрөгийн ширээ сандал шүүгээ, нэг бүлгийн хүүхдийн ширээ, сандал хувцасны шүүгээ, шарах шүүгээ, ЭМЯ-наас 4 ш иж бүрэн компьютер, ЭМТ-д ЭХЭМҮТ-өөс 150.0 мян.төг-н эмэгтэйчүүдийн гар соруурын аппарат, Улаанбаатар Сонгдо эмнэлгээс 500.0 мян.төгрөгийн	Б-100

					эм, нэг удаагийн хэрэгслүүд тус туснийлүүлж үр өгөөжтэй ашиглаж байна. "Зуд ой хээрийн түймэртэй тэмцэхэд олон нийтийн чадавхийг бэхжүүлэх" ГРАНД-9187 төслийн санхүүжилтээр ковш, цахилгаан хөрөө, галаас хамгаалах хувцас, мотопомп, чиргүүлийн хамт, дуут дохио зэрэг техник хэрэгсэл нийлүүлж, ... өрхийн өвөлжөө хаваржааны газар засварлах, малчны бүлэг, хөршийн бүлгийг чадавхжуулах зэрэг үйл ажиллагаанд нийт ... төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн байна.	
	71	-Татварын эх үүсвэр болон ажлын байр нэмэгдүүлэх боломжтой чиглэлээр боловсруулсан ААН, хувь хүмүүсийн төслийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжиж ажиллана.			Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг, Сум хөгжүүлэх сан, МОН 9183 төсөл, 3 эх үүсвэрээс 152.7 сая төгрөгийг 21 иргэнд хөнгөлттэй нөхцөлөөр зээл олгосон.	ХШ-70
	72	-Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж үр ашгийг нэмэгдүүлнэ			Суманд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдэж байгаа ажлын явцад хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг 5 хүн, бүртгэлд авах үүрэг бүхий ажлын хэсгийг 5 хүний бүрэлдхүүнтэй тус тус томилсон сумын Засаг даргын захирамжаар байгуулж, ажлын хэсэг явц болон гүйцэтгэлд хяналт тавьж ажилласнаар гүйцэтгэл сайжирч үр ашиг нэмэгдэж, хяналт сайжирч байна.	ХШ-70
	73	-Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоог жил бүр нэмэгдүүлж, иргэдийг учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх даатгалын хамрах хүрээг өргөжүүлэн давхар даатгалын системийг хэрэгжүүлнэ.			Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, болон ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдэд сурталчилан нийгмийн даатгалд хамруулж тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох нөхцөл бололцоог бүрдүүлж ажиллаа. 2018 онд 28 иргэн НД-д хамрагдсан, энэ онд 42 иргэн даатгуулагчийг НД-д шинээр хамруулсан. Давхар даатгалын тогтолцоог 2020 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөж байна	Б-100
	74	-Хэрэгцээнд суурилсан хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулж, үр нөлөөг дээшлүүлнэ			Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлтийг сумын бүх иргэдээс санал авч эрэмбэлэн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой орон нутагт зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын ажил, төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу үр ашигтай зарцуулахаар төлөвлөн сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж ажил үйлчилгээнүүдийг хугацаанд нь бүрэн, чанартай хийж гүйцэтгүүлж байна.	ХШ-70
Долоо:Хөдөө аж ахуй						
1.Бүс нутгийн онцлогт тохирсон бэлчээрийн болон эрчимжсэн МАА-г хөгжүүлж халдварт болон паразит өвчний гаралт тархалтыг эрс бууруулж МАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл борлуулалтыг нэмэгдүүлнэ.						
	75	Орон нутгийн байгаль цаг уурын			2015 онд ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 19	ХШ-70

		шалгарлыг давах чадвартай, чанар сайтай мал сүргийг түлхүү өсгөн шилмэл омгийн үхрийг гарган баталгаажуулж цөм сүрэг бүрдүүлнэ.			Сэлэнгэ үүлдэрийн өсвөр насны хээлтүүлэгчийг Дархинт багийн иргэдэд гэрээгээр эзэмшүүлсэн. 3-н жилийн байдлаар 1000 орчим төл хүлээн авсан. Үүнээс: 2018 онд Уялган багийн малчдад 13, 2019 онд 27 өсвөр насны хээлтүүлэгчийг Үүр багт-13 Булган багт -4, Уялган багт-7 тус тус нийлүүлж шилмэл омгийн мал, цөм сүргийг бий болгох угтвар нөхцөлийг бүрдүүлж байна.	
	76	-Малын үржлийн ажилд биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлж үхэр сүргийг махны чиглэлийн хээлтүүлэгчээр сэлбэнэ.			Малын генетик нөөцийн тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан малын үржлийн нэгжийг аж ахуйн тооцоон дээр тулгуурлан байгуулж шилмэл омгийн хээлтүүлэгчийг төвлөрүүлэн үржилд оруулахын зэрэгцээ биотехнологийн аргаар үр шилжүүлэн суулгах ажлыг хийхээр төлөвлөж байна.	ХШ-40
	77	-Мал сүргийн оновчтой бүтцийг бүрдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхой болгоно. Мах боловсруулах стандартын бага оврын үйлдвэр цех байгуулж хоёрдогч түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн шугам тавина.			Мал сүргийн гарал үүслийг тодорхой болгох зорилгоор Хөдөө аж ахуйн яамнаас Удам зүйн программыг 2019 оны 3 дугаар сараас ашиглаж эхэлсэн. Үхэр сүргийн 51 хувийг оруулсан Мах бэлтгэх, боловсруулах жижиг үйлдвэр цехийг байгуулхаар төсөл боловсруулагдан ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.	ХШ-40
	78	-Бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх, талхагдалтыг багасгах зорилгоор адуу болон эр сувай малыг ялган зуны оторт гаргаж алслагдсан нутаг, бэлчээрийг ашиглах боломжийг хангах зорилгоор дэд бүтэц, тав тухтай орчин, урамшууллын механизмыг бүрдүүлнэ.			Баг бүрт бэлчээрийг хувиартай ашиглах зорилгоор хашаа хөцөөг засварлах, бэлчээр менежментийг сайжруулах ажлыг ОНХС, төсөл хөтөлбөр болон малчдын идэвхи оролцоотойгоор шийдвэрлэж байна. Эр, сувай малыг зуны оторт гаргах ажил хийгдэхээр төлөвлөж багийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн ч явах хүн олдохгүй байна. Малчин өрхийн 70 гаруй хувь буюу 25.000 толгой мал өвлийн отроор явж байна.	ХШ-70
	79	-Мал, амьтны гаралтай өвчний голомтыг устгах, ариутгах, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулж ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлнэ.			Сэг зэм гарсан 22 газар, 104 малын хашаа хороо, Үүр багийн малчин Б.Лхагваа, Уялган багийн малчин Н.Даваадоржийн Бэлчээрийн талбай 550 м ² малын бэлчээрийн талбай, 2019 онд нийт 11777 м ² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийгдсэн.	Б-100
	80	-Малын халдварт өвчний тандалт хяналтыг тогтмолжуулж эрсдэл бүхий газрын мал сүргийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж үр дүнг тооцож ажиллана			2019 онд урьдчилан сэргийлэх арга хэмжээнд: Галзуугийн вакцинд 299 нохой; ДХХ хос цэнэт 997 бог, Дуут хавдар 2991 үхэр; Колибактериоз-ижбалнад 1196 бог, Боом 11963 үхэр; ДХХ-энтеробактериоз 664 бог, Цусан халдвар 2792 үхэр, Тугалын ижбалнад 199 тугал, Бруцеллөз 3290 эм тугал, 3191 богийн эм төл, ДХХ-энтеробактериоз 930 богийг хамруулсан. 22500 мал, амьтан хамруулахаас 29042 мал хамруулж гүйцэтгэл 129%-тай. Арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавин ажилласан.	Б-100

86	-Нэн ховор, ховор ан амьтны тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, амьдрах орчны үнэлгээ хийж нутагшуулан байршуулах, тоо толгойг тогтвортой өсгөн хамгаалалтын горимд оруулах бэлтгэл, зохион байгуулалтын арга хэмжээ авна.				Суманд үйл ажиллагаа явуулж байгаа ойн нөхөрлөлүүдийг түшиглэн хариуцаж байгаа ойн сан бүхий газар нутагт ан амьтан нутагшуулах, өсөж үржих нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор 4 ойн нөхөрлөлийг ангийн нөхөрлөл болгохоор FAO-ын төслөөс үйл ажиллагааг нь дэмжиж сургалт, тоног төхөөрөмж, ангийн мониторинг судалгаа хийлгэж урамшуулал олгосон байна. Мөн Цахир нөхөрлөлийн ангийн мониторинг судалгаан дээр үндэслэн биологийн төрөл зүйлийг хамгаалах төсөл хэрэгжихээр судалгааны шатандаа явж байна.	ХШ-70
87	-Агнуурын бүс нутгийг тогтоон хариуцагчидтай болгох, нутгийн иргэдийн болон ойн нөхөрлөлүүдийн хамгаалалтанд авахуулах, хууль бус агнуурын эсрэг тэмцлийг эрчимжүүлж, тусгай зориулалтаар ан агнах, загас барих ажлыг хяналтын дор зохион байгуулж орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.				2017-онд сумын ИТХ-аар агнуурын бүс нутгийг тогтоож, тогтоол гарган мөрдүүлэн ажиллаж байна. Хууль бус ан агнууртай тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор голуудын сав д Хилийн цэрэг, Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч, багийн засаг дарга, цагдаа, татварын байцаагч нартай хамтарч хилийн бүсэд амьдарч байгаа иргэд, хил хамгаалах туслах хүчний гишүүдэд Хилийн тухай хууль, Амьтны тухай хуулиар сургалт хийсэн. нийт 45 хүн оролцсон Уялган, Дархинт багийн айл өрхөөр явж Зөрчлийн тухай хууль, Татварын тухай хууль, Амьтны тухай хуулиар сурталчилгаа хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан. Амьтны тухай хуулиар 250 ш тараах материал бэлтгэж иргэд хүргүүлсэн. Амьтны тухай хуулийн хэрэгжилтэнд Үүр, Уялган, Ариг, Дархинтийн голын сав дагуу 5 удаа хяналт шалгалт хийж загас барих зорилготой явсан 18 иргэний үйл ажиллагааг зогсоосон. Орон нутгийн орлогод 8 сая төгрөгийн тусгай төлбөр төлж загас барих үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын иргэдийн үйл ажиллагаанд тухай бүр хяналт тавин ажиллаж төлбөр хураамжийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.	ХШ-70
88	-Ойн дагалт баялаг \самар, жимс\, байгалийн ургамлыг \цайны, эмийн\ үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх бүсийг тогтоон иргэд, ААН-ээр зохион байгуулалттай бэлтгүүлнэ.				Одоогоор ОН орлогот байгалийн дагалт баялаг ашигласны хураамж 567.000 төгрөгийг хуримтлуулсан. Байгалийн ургамлыг ашиглах нөөц тогтоох, бэлтгэх бүсийг тогтоогоогүй байгаа боловч хувиараа цайны ургамал түүж бэлтгэж нийлүүлдэг иргэд байна. Мөн энэ онд ахуйн зориулалттай самар бэлтгэх сайдын тушаал гарсантай холбогдуулан самрын нөөц ашигласаны хураамж 20.0 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.	ХШ-40

	89	-Ойн цэвэрлэгээний ажлын цар хүрээг өргөтгөн замын нь сүлжээг сайжруулж, түймэрт өртсөн болон хөгшин ой, унанги модыг эдийн засгийн эргэлтэнд оруулах зорилгоор орчин үеийн дэвшилтэт технологи бүхий иж бүрэн боловсруулах үйлдвэрийн шугам тавьж, ажиллагааг эхлүүлнэ.				Азийн хөгжлийн банк Онцгой байдлын ерөнхий газартай хамтран хэрэгжүүлж байгаа "Зуд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн чадавхийг бэхжүүлэх" нэгдсэн төсөлтэй хамтран Онгон ууланд 500*40м өргөнтэй түймрээс хамгаалах халз зурвасыг албан газруудын албан хаагчдын хүчээр байгуулсан. Мөн японы Сумомито корпорацийн хүнд аж үйлдвэр хариуцсан захирал газар дээр нь ирж хөгшин ой түймэрт шатсан ой ,унанги модыг цахилгаан станцын түлшинд хэргэлэх судалгааг хийсэн.	ХШ-70
2.Хог хаягдлыг баялаг болгох замаар байгальд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулна.							
	90	-Хог хаягдлыг стандартын савтай болгон ангилах, дахин боловсруулах, цуглуулах, тээвэрлэх, эргүүлэн ашиглах, байгальд ээлтэй аргаар устгах ажиллагааг журамлан зохицуулж хогийн менежментийг сайжруулна.				ХНБЦГ-ын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөлтэй хамтран албан газрууд нийтийн эзэмшлийн газруудад 22.969.960 төгрөгний үнэ бүхий стандартын хогийн сав, 00-ыг байршуулж, "Итгэл" хогийн бүлгийг ажлуулж нэгдсэн журмаар хогийн цэгт хүргэх үйлчилгээг эхлүүлсэн.Байгаль хамгаалах сарын аяны хүрээнд гялгар уутнаас татгалзах,даавуу тор ашиглаж хэвших,нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдалыг багасгах,нийтийн эзэмшлийн талбайд хогын сав байршуулж,сумын төвийг бүхэлд нь хянах камер тавьсан.	ХШ-70
	91	-Хогийн төвлөрсөн цэгийг журамлан эмх цэгцэнд оруулж харуул хяналтыг сайжруулна.				Хогийн төвлөрсөн цэгийг хашаажуулж ойр орчмын хогийг иргэдийн хүчээр цэвэрлэж хогийн цэгийн талбайг эмх цэгцтэй болгох, хогийг нэгдсэн журмаар тээвэрлэх үйлчилгээг иргэддээ үзүүлж байна. Аймгийн Засаг даргын баталсан журмын дагуу хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулахаар төлөвлөж байна.	ХШ-70
	92	-Зам дагуу болон уул овоо, тахилгат газар, голын эргээр хог хаях явдлыг цээрлэн түүнд тавих хараа хяналтыг сайжруулж, хог болох зүйлсийг төвлөрсөн цэгтэй газар хүргэж байх дадлыг иргэдэд хэвшүүлнэ.				ХНБЦГ-ын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих,тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслөөс "Итгэл" хог хаягдалын бүлгийг сонгон шалгаруулж сумын нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдалыг цэвэрлэх ачих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.Мөн зам дагуух болон дурсгалт газруудын хог хаягдалыг ачиж цэвэрлэн хогийн нэгдсэн цэгт хүргэж байна. Хог хаягдалын бүлгийн цалин хөлс, нормын хувцас, багаж тоног төхөөрөмжийг төслийн зүгээс шийдвэрлэсэн боловч төслийн санхүүжилт дууссан тул 2020-оноос дотоодын нөөц боломжинд тулгуурлан санхүүжүүлж тогтвортой байдлаа хадгалан ажиллах зорилттой байна..	Б-100

3.Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэн “Умард Саяны байгалийн цогцолбор газар” болгон Үүр, Уялган голуудын эхний сав газрыг хамруулан хамгаалалт, удирдлагын чадавхийг сайжруулна.

	93	-Хөх гол, Хэвэн, Цагааны Өндөр, Ажигийн Цагаан сарьдаг, Могой, Армагийн эхний уул нуруудыг улсын тусгай хамгаалалтанд оруулах санал боловсруулж холбогдох байгууллагуудад зохих журмын дагуу тавьж шийдвэр гаргуулна			Тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөх, биологийн төрөл зүйлийг хамгаалах зорилгоор судалгаа шинжилгээний ажлыг доктор Энхтайван хийж холбогдох газруудад хүргүүлээд байна. Дорнод Саяаны байгалийн цогцолборт газар байгуулах ажлыг ЗГ-ын түвшинд хэлэлцэж байна.	ХШ-70
--	----	--	--	--	---	-------

Ес.Аялал жуулчлал

1.Аялал жуулчлалыг сумын эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж үзэсгэлэнт байгаль, түүх соёлын дурсгалд түшиглэсэн нутгийн иргэдэд үр өгөөжтэй байхаар зохион байгуулна

	94	-Аялал жуулчлалын улирлын хамаарлыг багасгаж гадаад, дотоодын амрагч аялагчидад зориулсан амралт зугаалгын бүсчлэлийг тогтсон тав тухтай үйлчилгээ сайтай орчинг бүрдүүлж “Найрсаг Цагаан-Үүр” хөтөлбөр хэрэгжүүлнэ.			“Шагайн тойром” “Мөсний баяр” “Ургийн баяр” “Алунгоо хатны баяр” “Овоо тахиx бэсрэг наадам” “Нүүдэлчин монгол-Өв соёлын их наадам” зэрэг аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдэд зохион байгуулалттай оролцож, Аялал жуулчлалын эвент арга хэмжээний тоо нэмэгдэж, үйл ажиллагаа тогтмолжсоноор 2018 онд дотоодын аялал жуулчлалаар 2200 орчим, гадаадын жуулчдын тоо 48 хүрч Даян дээрхийн агуйг түшиглэсэн өвлийн аялал жуулчлал хөгжих эхлэл тавигдсан.2019 онд “Даян Дээрх Суварга ханы тахилга” үндэсний шагайн тойрмыг МОН-9183 төсөл болон нутгийн уугуул иргэдтэй хамтран зохион байгууллаа.Сумын тэргүүлэх чиглэлийн нэг аялал жуулчлалын салбарын хөгжилийг шинэ шатанд гаргах зорилгоор сумандаа аялал жуулчлалын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулж,аялал жуулчлал эрхлэх сонирхолтой иргэдэд туршлагатай багш нарыг ирүүлж зочлох үйлчилгээний сургалтыг 7сая орчим төгрөгийн санхүүжилтээр МОН-9183 төслийн багтай хамтран зохион байгууллаа.	ХШ-70
	95	-Даян Дээрхи, Алунгоо хатны хөшөө, Хөвсгөл нуурын чиглэлийн аялалын маршрутуудыг тогтмолжуулж дэд бүтцийг сайжруулан, түр буудаллах газар, нэрийн бүтээгдэхүүн зэргийг бий болгон үйлчилгээг төгөлдөржүүлнэ.			Сумын аялал жуулчлалын талаар баримтлах бодлогыг боловсруулж, Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөнд Уялган голд “Монгол бөхийн шүтээн” цогцолбор байгуулах санал дэмжигдсэн. ХНБЦГ-ын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөлтэй хамтран “Даян дээрхийн цом” үндэсний шагайн тойрмыг 2 удаа зохион байгуулж, 2019 онд Даян Дээрхийн цом, Суврага ханы хишиг тахилга наадам зохион байгуулж аялал жуулчлалын евент арга хэмжээ болгон өргөжүүллээ.	ХШ-70

96	- Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой иргэн, ААН, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана.			Одоогоор "Хөвсгөл тревел" "Дэнжийн тал" "Залаат тур" зэрэг компаниуд тусгай сонирхолын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж орон нутгийн төсөвт жилдээ 9-10 сая төгрөгийн орлого оруулж байна. Дотоодын аялал жуулчлал Даян дээрхийн шүтээнд сүсэглэн мөргөх, байгалийн сайхныг үзэж сонирхох, 3 үндэстэн ястны аж амьдрал ахуй соёлыг үзэж сонирхох чиглэлээр жилээс жилд нэмэгдэж үүнийг дагаад нутгийн иргэдийн ашиг орлого нэмэгдэж байна.	ХШ-70
97	-Даян Дээрхи, Далх, Даян бүүвэй, Цагаан бурхан, Нармандал овоо, Суварга Хан ууланд хүндэтгэл үзүүлэх эртний зан үйлийг сэргээн мөргөлийн богино цагираг үүсгэж "Сэтгэлийг ариусгах гэгээрлийн хөтөч" аялалын маршрут гарган үйл ажиллагааг нээн эхлүүлнэ.			Даян Дээрхи, Далх, Даян бүүвэй, Цагаан бурхан, Нармандал овоо, Суварга Хан ууланд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2019 оноос зохион байгуулж эхэлсэн. Цаашид эвент арга хэмжээ болгон жил бүр зохион байгуулах зорилт тавин ажиллаж байна. Мөн сумын хэмжээнд аялал жуулчлалын шинэ маршрут гаргаж гадаад дотоодын зах зээлээс жуулчдыг татах чиглэлээр итвэхтэй үйл ажиллагаа явуулж байна.	ХШ-40
98	-Аялалын чиглэлүүдэд ариун цэврийн байгууламж болон түр буудаллах, алжаал тайлах цэгүүдийг барьж байгуулан нутгийн иргэдийг ажлын байраар хангана.			ХНБЦГ-ын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөлтэй хамтран сумын ИТХ-ын хуралдаанд отоглох цэг түүний ажиллах журам, хураамжийн хувь хэмжээг тогтоосон тогтоол гаргуулж отоглох цэгт ариун цэврийн байгууламж байгуулан нэг иргэнд хүлээлгэн өгсөн. Даян дээрхи чиглэлд жуулчин хүлээж авах бааз, отоглох цэгийг нэмэгдүүлэх төсөл хийгдэж үйл ажиллагааг нь эхлүүлэх ажил гэрээ хэлэлцээрийн түвшинд явагдаж байна.	ХШ-40
99	-ОХУ-ын Түнкэн, Закаменьск район, Улаан –Үүд, Иволга, Санагын дацан, Байгаль нуур орчмын аялал жуулчлал эрхлэгч нартай идэвхтэй хамтын ажиллагааг эхлүүлнэ			Өвлийн аялал жуулчлалын арга хэмжээ "Пресс Фиш" 2018 арга хэмжээнд оролцож ОХУ-ын Иркутск хотын хэвлэл мэдээллийн салбарынхантай аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах, хамтын ажиллагааг эхлүүлээд байна. 2020 оны Иркутск хотод зохион байгуулагддаг аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт оролцох зорилготой байна.	ХШ-40
100	- Аялал жуулчлалын салбарт мэдээлэл, техник технологийн дэвшил, цахим систем нэвтрүүлнэ.			Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх зорилгоор сумын танилцуулга, тараах материалыг олон нийтийн цахим сүлжээ болон аймгийн нэгдсэн сайтад оруулахаар төслийг бэлэн болгосон.	ХШ-70

Арав.Сумын төв, суурин газар

1.Сумын төвийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг эдийн засгийн хөгжлийн нийтлэг шаардлага, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэн ард иргэдийн ая тухтай орчинд амьдрах таатай нөхцлийг бүрдүүлнэ.

101	-Төвийн гудамж хорооллыг үе шаттай сайжруулан журамлаж иргэд, айл өрхүүдийн тав тухтай, эрхээ эдэлж үүргээ биелүүлж амьдрах бололцоог бүрдүүлнэ.			Гудамж хорооллын эмх цэгцийг сайжруулах, иргэдийн газар өмчлөх, эзэмших ,ашиглах, гэрээ гэрчилгээнд хяналт тавих зорилгоор сумын засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилогдон нэг сарын аян зохион байгуулж иргэдийн газар эзэмших, өмчлөх, ашиглах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж зөрчлийг арилгуулан гудамж хороололыг эмх цэгцтэй болгох, өнгө үзэмжийг сайжруулан хашаандаа сайхан амьдрах нөхцөл боломжийг иргэд өөрсдийн хүчээр бий болгох талаар харилцан тохиролцож 2019 онд аймгийн газрын албатай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	ХШ-40
102	-Айл өрх, үйлчилгээний газруудыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ.			Судалгааны ажил хийгдэж зөвлөх үйлчилгээний тендер зарлагдаж ажлын даалгавар, ТЭЗҮ боловсруулсан.	ХШ-40
103	-Хувийн орон сууц, эдэлбэр газартай айл өрх, хүмүүсийн өмчлөх эрхийг баталгаажуулна			Суманд нийт 418 эзэмшигч 127 газраа өмчилсөн иргэд байна.	ХШ-40
104	-Ашиглалтын шаардлага хангахгүй, хугацаа дууссан орон нутгийн өмчтэй барилга, объектуудыг буулгаж, шинэчлэн сэргээх ба гэр хорооллыг дахин төлөвлөлтөнд оруулж сайжруулна, “Шинэ хороолол”, “Жишиг хороолол” төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.			Орон нутгийн өмчтэй барилга байгууламж болох ЕБСургуулийн хичээлийн байр, соёлын төвийг буулган газар чөлөөлсөн. 2019 онд ЗДТГ-ын Б байр, цагдаагийн 2 айлын орон сууцыг дуудлага худалдаа зохион байгуулж газар чөлөөлөх ажил хийгдэхээр болсон. Эрүүл ахуйн стандарт шаардлага хангахгүй болсон ЕБС-ийн барилга байгууламжийг акталж газар чөлөөлөх саналыг аймгийн ИТХ-д уламжилсан.	ХШ-70
105	-Төв доторх авто машин зорчих нийтийн замыг засаж тэмдэгжүүлнэ.			Сумын төвийн төв зам дагуу газруудад авто машины тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагчийг өмнөх онуудад хийсэн. 2019 онд сумын төвийн зам засварт ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 68.956.265 сая төгрөгийн санхүүжилтээр АЗЗА ХХК зам засварын ажлыг гүйцэтгэж 7км замыг засварласан.	Б-100
106	-Төв суурин газрын газар олголт, ашиглалтыг сайжруулан, үйл ажиллагаа эрхлээгүй газрын эзэмших эрхийг цуцлах, дуудлага худалдаанд оруулах, газар олголтыг ил тод болгож, гэр бүлийн хэрэгцээний газар өмчлөлийг нэмэгдүүлнэ.			Суманд нийт 389 эзэмшигч 127 газраа өмчилсөн иргэд байна. Газрын мэдээллийн сан цахим хэлбэрт шилжиж байгаа тул иргэд өөрийн мэдээллийг цахим сүлжээгээр авах боломж бүрдэж байна.	ХШ-70
Арван нэг.Дэд бүтэц 1.Мэдлэг оюунд тулгуурласан ухаалаг, дэвшилтэт технологи бүхий найдвартай дэд бүтцийг бүрдүүлж иргэдийн ажиллах, амьдрах ,үйлчилгээ авах ээлтэй орчинг бүрдүүлнэ.					

	115	-Үүрийн голын бетонон гүүрнээс Даян Дээрхийн чиглэлд ЦДАШ 10квт-н шугамын ажлын ТЭЗҮ-г гаргаж зураг төсвийг боловсруулна.				Зураг төсвийн ажил хийгдэж санхүүгийн эх үүсвэр шийдэгдээгүй байна.	ХШ-40
	116	Артелийн лагерийн цахилгаан шугамын алдагдлыг шинээр бариглах дулааны зуухны дэд станцаас шууд холбох замаар эрчим хүчний хангамжийг сайжруулна.				Түлш эрчим хүчний яам Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж байгаа сумдын 04 ийн шугамыг шинэтгэх ажлын хүрээнд хүчдэлийн уналттай Артелийн лагерын чиглэлд агаарын цахилгаан дамжуулах 04шугамыг Энэрчи ХХК барьж айл өрхүүд өөрсдийн нөөц боломжоор холболтыг хийж гүйцэтгэсэн.	ХШ-40
В.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
Иргэдийн оролцоог хангасан төрийн ёс зүйтэй үйлчилгээг оновчтой бодлогоор удирдаж, хүний эрхийг дээдэлсэн сум болно							
Арван хоёр.Төрийн алба							
1.Төрийн албыг ил тод, нээлттэй, чадварлаг, мэргэшсэн, төвлөрөл багатай, иргэдээ дээдэлсэн хариуцлагатай алба болгоно.							
	117	Орон нутгийн хөгжлийн бодлогод санал дүгнэлт гаргах судалгаа шинжилгээ хийх, зөвлөн туслах эрдэмтэн, судлаачид, ахмад настан, нутгийн сэхээтнүүдийг оролцуулсан орон тооны бус бодлогын зөвлөлийг Засаг даргын дэргэд байгуулж ажиллуулна.				Орон нутгийн хөгжлийн бодлогод судалгаа шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх орон тооны бус зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр Засаг даргын дэргэд байгуулсан бөгөөд санхүү хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүйгээс үйл ажиллагаа нь тогтмолжоогүй байна.	ХШ-70
	118	-Үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж авлига, хүнд суртлаас ангид, иргэдийн сэтгэлд хүрсэн үйлчилгээг бүрдүүлнэ.				Иргэдэд үйлчлэх шат дамжлагыг багасгах зорилгоор сумын ЗДТГ-т нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлсэн бөгөөд ЗДТГ-ын байрны хүртээмжгүй байдлаас ажиллах боломжгүй болсон. Иргэдтэй үйлчилдэг албан хаагч нар тухайн төрийн үйлчилгээг авахад шаардагдах бүрдүүлэх материалын жагсаалтыг гарган хавтаслаж ЗДТГ-ын үүдэнд байршуулсан.	ХШ-70
	119	-Төрийн албаны бодлого, үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагын санал, дүгнэлт, сэтгэл ханамжийн байдлыг харгалзана.				Сумын эрх зүйн хөтөч баг Уялган багийн 55 өрхөөс түүвэр байдлаар төрийн байгууллагын үйлчилгээний талаархи сэтгэл санамжийн судалгааг авсан бөгөөд нийт төрийн байгууллагын үйл ажиллагааг 69 хувьтай гэж дүгнэсэн байна. Үзүүлэлтийг урьд оны сэтгэл ханамжийн судалгаатай харьцуулахад 8 хувийн өсөлттэй гарсан байна.	Б-100

	120	-Төрийн албан хаагчийн ёс зүйн үнэлэмж, төлөвшлийг төрийн албаны үндсэн шалгуур болгоно.				Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, багшийн ёс зүйн дүрэм, эмч, эмнэлэгийн ажилтны ёс зүйн дүрэм зэрэг салбар салбарын ёс зүйн дүрмийг орон нутгийн онцлог, шаардлага, нөхцөл байдалд нийцүүлэн үлгэрчилсэн загварын дагуу баталж албан хаагч нэг бүрт хүргүүлсэн. ТАХ-ын ёс зүйн талаарх өргөдөл гомдлын мэдээллийг ЗДТГ-ын ёс зүйн хороо болон 89506569 нээлттэй утсаар тогтмол хүлээн авдаг. Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн талаархи 2 өргөдөл гомдлыг журмын дагуу шийдвэрлэж арга хэмжээ авсан.	ХШ-70
	121	-Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг бодитой үнэлж, урамшуулал болон хариуцлагын тогтолцоог бий болгоно.				Албан хаагчдын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас бүтэн жилээр үнэлж дүгнэх ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар томилдог бөгөөд хангалттай үнэлэгдсэн албан хаагчдад урамшуулал олгох хангалтгүй үнэлэгдсэн албан хаагчдад хариуцлага тооцдог.	Б-100
	122	-Төрийн жинхэнэ албаны томилгоог улс төрөөс ангид, мэргэшсэн, тогтвортой байх зарчимд тулгуурлан хийх бодлого хэрэгжүүлнэ.				Төрийн жинхэнэ албаны сул орон тоо 1, мал эмнэлгийн тасагт 1, ХАА-н тасагт 1 ажлын байр гарч төрийн албаны салбар зөвлөлд захиалга хүргүүлсэн байна.	ХШ-70
Арван гурав.Хууль зүй 1.Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд технологийн шинэчлэл нэвтрүүлж, эрх зүйн сургалтын үр дүнг дээшлүүлэн иргэдийн аюулгүй амар тайван амьдрах орчинг бүрдүүлж аливаа хяналт шалгалтыг нийгмийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглүүлнэ.							
	123	-Иргэний танхимыг нээн байнгын ажиллагаатай болгон "Иргэний боловсрол" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.				"Иргэний боловсрол" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 4 зорилт 15 арга хэмжээ бүхий төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд иргэний танхимын барилгыг 2019 оны 6 сарын 01-ны дотор ашиглалтанд хүлээлгэж өгөх аймгийн дотоод хяналт, аудитын албан шаардлагыг гүйцэтгэгч комданид хүргэгдсэн боловч асуудлыг одоо болтол шийдвэрлээгүй байна.	ХШ-40

124	-Мэдээлэл сурталчилгааны баг байгуулж, орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийг бий болгон хамтын ажиллагааг өргөжүүлнэ.			Сумын эрх зүйн хөтөч баг улирал бүр хөдөөгийн багийн иргэдэд хүрч үйлчлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Энэ онд нийт 3 удаагийн хөдөөгийн багт ажиллах удирдамжийн дагуу ажиллаж давхардсан тоогоор 1750 иргэнд төрийн үйлчилгээг хүргэсэн байна. Улирал бүр "Цагаан-Үүрийн мэдээ" сонинг хэвлэн гаргасан бөгөөд нийт 3 удаагийн 820 сонин хэвлэгдэн хөдөөгийн малчин иргэдэд тараагдсан байна. Уг сонингоор бид сум орон нутагт зохион байгуулагдсан томоохон арга хэмжээ, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт болон сэрэмжлүүлэг, мэдээ мэдээлэл, хууль эрх зүйн танилцуулга зэргийг багтаасан болно. Мөн аймгийн "Хөвсгөл ард түмний телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулан 3-н телевизын нэвтрүүлэг, 4 удаагийн сурвалжлага хийлгэж аймгийн хэмжээнд нэвтрүүлсэн байна. Эрх зүйн хөтөч энэ онд нийт 2602 ширхэг тараах материал боршур тараасан байна. Үүнд: Цагаан-Үүрийн мэдээ сонин 820, сайн дурын даатгалын боршур 192, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх боршур-540, малын генетик хуулийн тухай боршур -320, халамжийн сангийн төсөл хөтөлбөрт хамрагдах тухай боршур-250, зудыг давсан зузаан туршлага тохимол-150, Орон нутгийн хөгжлийн сангийн танилцуулга-280, албан байгууллагын албан хаагчын утасны жагсаалт-55 ширхэг тараагдсан байна.	Б-100
125	-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан нөхцлийг арилгах, илрүүлэх ажилд олон нийтийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах хөтөлбөр гаргаж урамшуулах нэрэмжит шагнал бий болгоно.			Сумын хэмжээнд 6 малчдын бүлэг, 18 ойн нөхөрлөл, 8 хөршийн бүлэг байгуулан мал, орон байрын хулгай, байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчилөөс урьдчилан сэргийлэх ажлыг сумын ГХУСАЗСЗөвлөл, хамтарсан баг, БОТХБТасгаас хамтран зохион байгуулж зөвлөмж зөвлөгөө сургалт мэдээллийг шат дараатай хэрэгжүүлж байна. Мөн хууль бус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд сумын төвд 360 градус эргэлддэг камерыг байршуулсан байна.	Б-100
126	Мэдээлэл дамжуулах иргэдийн сүлжээг бий болгож, ажиллах нөхцлөөр хангана			Хууль бус ан агнууртай тэмцэх тэднийг таслан зогсоох зорилгоор идэвхитэн байгаль хамгаалагч нарыг томилж Дархинт багийн 9 иргэнд 450.0 мян төгрөгийн урамшуулал олгов.	ХШ-70
127	Цагдаагийн ажилтнуудын чадавхи, бэлэн байдал, нийгмийн баталгааг хангаж иргэдэд ил тод нээлттэй болгох, үүрэг хариуцлагыг нь сайжруулан иргэдийн итгэх итгэлийг нэмэгдүүлж нэр хүндийг нь өсгөнө.			Цагдаагийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор албаны ширээ сандал мотоциклийг ОНХС-ын хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн.	ХШ-70

	128	-Хил хамгаалах байгууллага, туслах хүчний гишүүдийн хамтын ажиллагааг идэвхжүүлж хилийн манааны байр, дулаалцах түр байруудыг бий болгоно.ОН-ийн, иргэдийн санаачлагын,төсвийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ			Хил хамгаалах туслах хүчний 2019 оны нэгдсэн төлөвлөгөөний дагуу хилчин танхим байгуулах, хилчний дулаацах байрыг засварлах, буудлагын талбайг тохижуулахад Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн "Хэлгүй жим" түүхэн уран сайханы кино бүтээг ажилд төсвийн байгууллага бүр дэмжлэг тусалцаа үзүүлэн хамтран ажилласан.	Б-100
	129	Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн ажиллагаанд мэдээлэл технологийн ололтыг нэвтрүүлж , хадгалалт хамгаалалтыг сайжруулна -Архивын нөхөн бүрдүүлэлтийг хийлгэж, байгууллагын болон төрийн архивын баримтын эрэл хайлт, тоо бүртгэл, мэдээллийн сантай болгон шаардлагатай лавлагаагаар иргэдэд үйлчилгээ үзүүлнэ			Аймгийн Архивын тасгийн нөхөн бүрдүүлэлтийн хуваарийн дагуу 1 сумын 1-р данс 1978-1990 он, 2 – р данс 1992-2014 оны захирамжлалын баримтыг цахим архивт бүрэн хийж гүйцэтгэсэн. 2.Архив,албан хэрэг хөтлөлтийн программ худалдан авч суурилуулан ажиллаж байна. 2019 онд 58 иргэнд архивын лавлагаа олгосон.	Б-100
Арван дөрөв. Худалдан авах ажиллагаа						
1.Худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын хүний нөөцийг хөгжүүлж, техник технологи, программ хангамж ашигласнаар өрсөлдөх тэгш боломж, ил тод, нээлттэй, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг хангана.						
	130	-Төрийн болон төсөвт байгууллага, орон нутгийн ААН-ийн хэрэгцээнд бараа, ажил үйлчилгээ нийлүүлэгч, гүйцэтгэгчийг цахим тендерээр шалгаруулна.			2019 оны ХАА-ны төлөвлөгөөг сумын ИТХ-ын 2018 оны ээлжит 8 дугаар хуралдааны 6 дугаар тогтоолоор батлуулан тендер шалгаруулалт, цахим мэдээллийн хаягт байршуулж холбогдох хууль, дүрэм, журам, зааврын дагуу явуулж ирсэн.Гүйцэтгэлд дотоод хяналтын нэгжүүд хяналт тавьж, үр дүнг тухай бүрт нь байгууллагын мэдээллийн самбар, shilendans.gov.mn сайтад байршуулж иргэдэд ил тод мэдээлж байна.	ХШ-70
	131	-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүнг ашиг хүртэгч иргэд, олон нийтээр үнэлүүлдэг тогтолцоог бүрдүүлнэ.			Суманд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдэж байгаа ажлын явцад хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр сумын Засаг даргын захирамжаар байгуулж, ажлын хэсэг явц болон гүйцэтгэлд хяналт тавьж, зарим ажлын гүйцэтгэлд иргэдээс төлөөлөл оролцуулж ажилласнаар гүйцэтгэл сайжирч үр ашиг нэмэгдэж, хяналт сайжирч байна.	Б-100
	132	-Тендер шалгаруулалтанд дотоодын давуу эрх тооцох замаар орон нутгийн ААН-үүд худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчээр сонгогдох давуу боломж олгоно.			Тендер шалгаруулалтанд дотоодын давуу эрх тооцох замаар орон нутагт бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулж "Нараншивээт" "Бундан цахир" "Тэвгэр Асга" "Үүрийн Ундарга" "Батчаг" "Гэдгэр хайрхан" "Хүнхэр сарьдаг" ХХК-иудад төрийн байгууллагад бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх эрх олгож ажиллалаа.	Б-100
		-Орон нутагт үйлдвэрлэсэн бараа, ажил үйлчилгээг төрийн болон төсөвт байгууллагуудад худалдан авч хэрэгжүүлэх бодлогыг баримтлана.			Мах сүү, гурилан бүтээгдэхүүн, хүнсний ногоо, цагаан идээг тендерт шалгарсан компаниудаар дамжуулан үйлдвэрлэгчдээс төсөвт байгууллагуудын хэрэгцээнд нийлүүлж байна.	Б-100

ТАНИЛЦСАН: ЗАСАГ ДАРГА
ХЯНАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА
НЭГТГЭСЭН: ДАЭЗССХМЭРГЭЖИЛТЭН



Д.ДАЛАЙ
Д. ЦОГТ-ЭРДЭНЭ
Д. БОЛОР-ЭРДЭНЭ